# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# “ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН” НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

***Төсвийн байгууллага, орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд хэмнэлтийн бусад арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулаагүй, хуулиар хориглосон зүйлсэд 113.6 сая төгрөгийн төсвийг зарцуулсан зэргээс харахад удирдлагын түвшинд хариуцлагын тогтолцоо алдагдсаныг харуулж байна.***

**АУДИТЫН КОД: ХӨА-2025/21-21-ШТА-НА**


Дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Ахлах аудитор Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: ichinkhorlooga@audit.gov.mn
Аудитор Л.Мандахнаран
Утас: 92118277 Цахим хаяг: mandakhnaranl@audit.gov.mn
Аудитор Л.Мөнх-Оргил
Утас: 99039344 Цахим хаяг: munkh-orgill@audit.gov.mn
Аудитор Б.Ариунтуяа
Утас: 99036832 Цахим хаяг: ariuntuyab@audit.gov.mn
Аудитор Х.Энхтуяа
Утас: 89182456 Цахим хаяг: enkhtuyakh@audit.gov.mn


**Хөвсгөл аймаг**

**2025 он**


Энэхүү тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.khuvsgul.audit.mn

# АГУУЛГА


| Агуулга | Хуудасны дугаар |
|---|---|
| Товчилсон үгийн тайлбар | 3 |
| Аудитын тайлан баталгаажуулах тушаал | 4 |
| Аудит хийх үндэслэл, бүрэн эрх | 6 |
| Аудитын зорилт | 6 |
| Аудитын хамарсан хүрээ | 6 |
| Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт | 6 |
| Аудитын бүрэлдэхүүн, хугацаа | 6 |
| Үндсэн мэдээлэл | 7 |
| ***Бүлэг 1. Төсвийн байгууллага, орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд хэмнэлтийн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулаагүй, хуулиар хориглосон зүйлсэд 113.6 сая төгрөгийн төсвийг зарцуулсан зэргээс харахад удирдлагын түвшинд хариуцлагын тогтолцоо алдагдсаныг харуулж байна.*** | 8 |
| *А.1 Хуулийн 5-12 дугаар зүйлийн хэрэгжилттэй холбоотой 15.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.* | 8 |
| *А.2 Төсвийн байгууллага, орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд хэмнэлтийн бусад арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулаагүй, хуулиар хориглосон зүйлсэд 98.6 сая төгрөгийн төсвийг зарцуулсан зэргээс харахад удирдлагын түвшинд хариуцлагын тогтолцоо алдагдсаныг харуулж байна.* | 10 |
| ***Бүлэг 2. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний 56 хувь нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахгүй байна.*** | 13 |
| *Б.1 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний 56 хувь нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахгүй байна.* | 13 |
| *Б.2 Цахим дэлгүүрийн барааны үнэ өндөр, чанар хангалтгүй, бүтээгдэхүүний тоо хэмжээний хувьд хязгаарлагдмал байна.* | 14 |
| ***Бүлэг 3. Төсвийн хэмнэлтийг 2022-2024 онд нийт батлагдсан төсөвтэй харьцуулахад 1.2 орчим хувийг хэмнэсэн байгаагаас харахад сүүлийн жилүүдэд тус хуулийн хэрэгжилтэд тодорхой ахиц гаргахгүй байгааг харуулж байна.*** | 16 |
| *В.1 2022-2024 онд тус хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил дутагдал нэмэгдсэн нь хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагаас хуулийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүйг харуулж байна.* | 16 |
| *В.2 Төсвийн хэмнэлтийг 2022-2024 онд нийт батлагдсан төсөвтэй харьцуулахад 1.2 орчим хувийг хэмнэсэн байгаагаас харахад сүүлийн жилүүдэд тус хуулийн хэрэгжилтэд тодорхой ахиц гаргахгүй байгааг харуулж байна.* | 17 |
| *В.3 Мэдээллийн ил тод байдал хангалтгүй байна.* | 18 |
| Аудитын дүгнэлт | 20 |
| Аудитын зөвлөмж | 21 |
| Зөрчлийн нэгтгэл | 22 |
| Байгууллагын санал | 24 |
| Хавсралтууд | 27-4 |
| | |

## Товчилсон үгийн тайлбар

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АИТХ | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| УИХ | Улсын Их Хурал |
| ОНХС | Орон Нутгийн Хөгжлийн Сан |
| ОНХО | Орон Нутгийн Хөрөнгө оруулалт |
| ХАА | Худалдан Авах Ажиллагаа |
| УМС | Удирдлагын мэдээллийн систем |
| ТУЗ | Төлөөлөн Удирдах зөвлөл |
| ТӨҮГ | Төрийн өмчит үйлдвэрийн газар |
| ОНӨҮГ | Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар |
| ОНӨ ХХК | Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| СТСХ | Санхүү төрийн сангийн хэлтэс |
| ТБОНӨ | Төрийн болон орон нутгийн өмчит |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| ЭМТ | Эрүүл мэндийн төв |
| ТАХ | Төсөл арга хэмжээ |
| ТХТХ | Төрийн хэмнэлтийн тухай хууль |
| БХНСАХ | Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ |

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 22 өдөр Дугаар А/14 Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.1.10-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол улсын Ерөнхий аудиторын 2024 оны А/108 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн” нийцлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн төлбөрийн актыг хоёрдугаар хавсралтаар батлсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Эрсдэлийн удирдлагын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, аймгийн Боловсролын газар, аймгийн Эрүүл мэндийн газар, Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдэд тус тус хүргүүлсүгэй.

3. “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн” нийцлийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, үр дүнг 2025 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг холбогдох албан тушаалтанд зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор (Г.Ичинхорлоо)-д үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер (Б.Тэгшдэлгэр)-д даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2025 оны 05 дугаар сарын 12-ний өдрийн А/24 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

“Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн” нийцлийн аудитаар өгсөн төлбөрийн актын жагсаалт

| № | Төлбөрийн актын дугаар | Утга | Дүн төгрөгөөр |
|---|---|---|---|
| 1 | 80/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 774,300.00 |
| 2 | 81/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 2,921,140.00 |
| 3 | 82/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 8,126,802.00 |
| 4 | 83/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 13,647,348.00 |
| 5 | 84/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 2,864,615.00 |
| 6 | 85/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 817,400.00 |
| 7 | 86/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 1,330,000.00 |
| 8 | 87/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 585,000.00 |
| 9 | 88/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 438,900.00 |
| 10 | 89/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 6,253,027.00 |
| 11 | 90/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 1,152,622.00 |
| 12 | 91/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 4,563,715.00 |
| 13 | 92/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 7,534,322.00 |
| 14 | 93/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 9,257,836.00 |
| 15 | 94/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 700,000.00 |
| 16 | 95/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 1,578,530.00 |
| 17 | 96/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 325,200.00 |
| 18 | 97/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 2,333,893.00 |
| 19 | 98/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 4,238,870.00 |
| 20 | 99/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 2,450,000.00 |
| 21 | 100/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 5,595,566.00 |
| 22 | 101/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 2,313,504.00 |
| 23 | 102/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 698,800.00 |
| 24 | 103/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 1,008,186.00 |
| 25 | 104/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 2,600,039.00 |
| 26 | 105/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 2,547,623.00 |
| 27 | 106/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 2,159,317.00 |
| 28 | 107/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 3,658,110.00 |
| 29 | 108/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 2,742,041.00 |
| 30 | 109/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 702,540.00 |
| 31 | 110/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 624,580.00 |
| 32 | 111А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 1,391,007.00 |
| 33 | 112/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 2,702,935.00 |
| 34 | 113/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 4,214,216.00 |
| 35 | 114/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 1,013,767.00 |
| 36 | 115/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 758,884.00 |
| 37 | 116/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 985,934.00 |
| 38 | 117/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 2,972,050.00 |
| 39 | 118/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 439,134.00 |
| 40 | 119/А2270648/ХӨА-2025/21-21-ШТА-НА | Төлбөр барагдуулах тухай | 2,543,738.00 |
| **Нийт** | | | **113,565,491.00** |

| | |
|---|---|
| **Аудит хийх үндэслэл, бүрэн эрх** | Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.1.10-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын их хурлын төсвийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2024 оны А/108 дугаар тушаалыг тус тус үндэслэн гүйцэтгэлээ. |
| **Аудитын зорилт** | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд нийцлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилго чиглэгдлээ. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:<br>• Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажилласан эсэх<br>• Хөрөнгө оруулалттай холбоотой хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан эсэх<br>• Аймгийн Засаг дарга болон төрийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнтэй байсан эсэх |
| **Аудитын хамарсан хүрээ** | Аудитыг 2022, 2023 оны аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, 2022, 2023, 2024 оны Улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн, Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны төлөвлөлт, гүйцэтгэл, үр нөлөө, үр дүн, 2023, 2024, 2025 оны “Орон нутгийн төсвийн төсөлд санал дүгнэлт гаргах аудитуудтай уялдуулан, Төсвийн төвлөрүүлэн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагууд, зарим ТӨҮГ, ОНӨХХК-уудын 2024 оны санхүүгийн үйл ажиллагааг түүвэрт хамруулж холбогдох баримт материалын хүрээнд хийж гүйцэтгэлээ. |
| **Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт** | Аудитыг АДБОУС 100, 400, 4000-4200, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-4:2020, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, баримтад тулгуурлан судалгаа, шинжилгээ, харьцуулалт, баталгаажуулалт хийж, үр дүнг тооцох арга зүйг ашиглаж аудитыг гүйцэтгэсэн.<br>Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагууд болон боловсрол, эрүүл мэнд Соёлын салбарын байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, мэдээлэл, тодруулга авах, асуудал эрхэлсэн байгууллага болон холбоотой талуудаас гаргуулсан баримт, мэдээлэл, судалгаа, тайланг судалж, дүнг нэгтгэн аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, тэдгээрийн үр дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулсан. |
| **Аудитын бүрэлдэхүүн, хугацаа** | Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг журмын дагуу цуглуулж ажлын баримт материалд хавсаргасан болно.<br>Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хянан удирдаж, аудитын менежер Б.Тэгшдэлгэр аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Ичинхорлоо, аудитор Л.Мандахнаран, Л.Мөнх-Оргил, Б.Ариунтуяа, Х.Энхтуяа нар төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ. |

Аудитын урьдчилсан судалгаа, төлөвлөлтийн үе шатны ажлыг 2025 оны 02 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн 02 дугаар сарын 28-ний өдрийн дотор гүйцэтгэж, аудитын төлөвлөгөөг Тэргүүлэх аудитораар батлуулсан.
Аудитын талбарын ажлыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн 05 дугаар сарын 5-ны дотор гүйцэтгэж, тайлан, дүгнэлт боловсруулж ажилласан.

Аудитын тайланг 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн дотор Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан Үндэсний аудитын газар болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн.

Аудитын тайланд дэвшүүлсэн зорилт, хамарсан хүрээ, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжөөс гадна холбогдох байгууллагын саналыг тусгалаа.

**Үндсэн мэдээлэл**

Төрийн хэмнэлтийн тухай хууль нь 2022 онд 4 бүлэг 22 зүйл заалттай батлагдаж, Монгол улсын 2022 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн байна. Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2022 онд 1 удаа, 2023 онд 2 удаа, 2024 онд 3 удаа тус тус нэмэлт өөрчлөлт оруулж баталсан.

Төсвийн байгууллага болон төрийн болон орон нутгийн өмчит хуулийн өмчит нийт 251 байгууллагыг хамруулж, түүвэрлэн аудитыг гүйцэтгэлээ. Үүнээс:

**223 -** Төсөвт байгууллага
- **63** Орон нутгийн төсөвт байгууллага
- **160** Улсын төсвийн байгууллага

**28** ТБОНӨ хуулийн этгээд
- **4** Төрийн өмчит хуулийн этгээд
- **24** Орон нутгийн өмчит хуулийн этгээд

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газраас 2022-2024 онд гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудит, гүйцэтгэл, нийцлийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 56,902.3 сая төгрөгийн зөрчил илрүүлж, аудитын шийдлийг гаргаж ажилласан байна. Үүнд:

1. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 780.4 сая төгрөгийн зөрчил илрүүлсэн байна. Зөрчлийг шийдвэрлэсэн байдлыг харуулбал:

График №1 *\/сая төгрөгөөр/*




| | 2022 Тоо | 2022 Дүн | 2023 Тоо | 2023 Дүн | 2024 Тоо | 2024 Дүн |
|---|---|---|---|---|---|---|
| Төлбөрийн акт | 27 | 142.7 | 17 | 40 | 45 | 135.5 |
| Албан шаардлага | 8 | 208.6 | 2 | 9 | 9 | 100.5 |
| Зөвлөмж | 6 | 79 | 11 | 50.4 | 13 | 14.7 |

2. Гүйцэтгэл, нийцлийн аудитаар нийт 56,121.9 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж 5.0 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 3,529.7 сая төгрөгийн 6 албан шаардлага өгч, 52,587.2 сая төгрөгийн 7 зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлж ажилласан байна.

***БҮЛЭГ 1. Төсвийн байгууллага, орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд хэмнэлтийн бусад арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулаагүй, хуулиар хориглосон зүйлсэд 113.6 сая төгрөгийн төсвийг зарцуулсан зэргээс харахад удирдлагын түвшинд хариуцлагын тогтолцоо алдагдсаныг харуулж байна.***

***А.1. Хуулийн 5-12 дугаар зүйлийн хэрэгжилттэй холбоотой 15.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.***

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулж ажиллах чиг үүргийн дагуу аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын санхүү төрийн сангийн хэлтсээс дараах ажлуудыг хийсэн байна. Үүнд:

- Орон нутгийн төсөв батлах үед Төрийн хэмнэлтийн тухай хуулиар тогтоосон зарчмыг мөрдлөг болгож ажиллах чиглэлийг Сумдын Засаг дарга нарт жил бүр хүргүүлсэн байна.
- Аймгийн Засаг даргын 2023 оны 3 дугаар сарын 3-ний өдрийн А/91 дүгээр захирамжаар төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудад Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах арга хэмжээг авч ажилласан байна. Үүнд:
    1. Барилга байгууламжийн зураг төсөл, өртгийн төсөв, бараа ажил үйлчилгээний техникийн тодорхойлолтыг хугацаанд нь батлуулах
    2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, үр ашиггүй зардлыг бууруулах чиглэлээр арга хэмжээ авч ажиллах
- Аймгийн Засаг даргын зүгээс хуулийн 6 дугаар зүйлийн хэрэгжилттэй холбогдуулан 2023 оны 7 сарын 5-ны өдрийн А/403 дугаар захирамжаар төсвийн байгууллага, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ашиглах автомашины тоо, төрлийг тогтоож, ашиглалтгүй байгаа автомашинуудыг татан төвлөрүүлж, автомашин зайлшгүй шаардлагатай байгаа байгууллагад шилжүүлэх, стандартын шаардлага хангахгүй автомашиныг худалдан борлуулахаар шийдвэрлэсэн байна. Захирамжийн хэрэгжилтийг хянаж үзэхэд 2023 онд ашиглалтгүй байгаа 30 автомашиныг, 2024 онд 16 автомашиныг шаардлагатай байгууллагад шилжүүлж, 67 тээврийн хэрэгслийг дуудлага худалдаагаар худалдан борлуулж, 246.3 сая төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлсэн байна.

Аймгийн Боловсролын газар, Эрүүл мэндийн газар, Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газраас өөрийн харьяаны байгууллагуудад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлийг сургалт, зөвлөгөөнөөр өгч ажилласан байна.

Төрийн аудитын байгууллагаас 2022-2024 онд гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар хуулийн 5-12 дугаар зүйлийн хэрэгжилттэй холбоотой нийт 143.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд: /Зөрчлийн дэлгэрэнгүй жагсаалтыг хавсралт №1-ээс харна уу/

*Хүснэгт № 1* *(сая төгрөгөөр)*

| № | Хуулийн зүйл | Дүн | Тайлбар |
|---|---|---|---|
| 1 | 5 дугаар зүйл | 0.0 | Хуулийн хэрэгжилтийг хангаж 2022 онд Хөвсгөл аймгийн Хөдөлмөр халамж, үйлчилгээний газрын даргын дэд даргын орон тоог бүтцээс хассан байна. |
| 2 | 6 дугаар зүйл | 32.1 | Автомашин ашиглах эрхгүй албан тушаалтан дотор үйлчилгээнд автомашин ашигласан, албан томилолтоор ажиллаж шатахуун зарцуулсан нь холбогдох нотлох баримтаар дэмжигдээгүй, тод өнгийн улсын дугаар ашиглаагүй зэрэг зөрчил илэрсэн. |
| 3 | 7 дугаар зүйл | 39.9 | Урсгал засварын зардлаас конторын барилга бэлтгэсэн. |
| 4 | 8 дугаар зүйл | 1.3 | Байгууллагын төсвөөс биеийн тамирын хувцас болон ижил төрлийн албан хэрэгцээнд шаардлагагүй хувцас бэлтгэсэн. |
| **5** | 9 дүгээр зүйл | 0.9 | Албан томилолтоор ажилласан зардлыг 2 байгууллага давхардуулан гаргасан. |
| **7** | 12 дугаар зүйл | 69.6 | Албан хаагчдын гар утасны төлбөр төлсөн, шаардлагагүй хэвлэл захиалсан, байгууллагын үйл ажиллагаанд хэрэгцээгүй материалын худалдан авалт хийсэн зэрэг зөрчил илэрсэн. |

| | НИЙТ | 143.8 | |
|---|---|---|---|

Аудитаар хуулийн 5-12 дахь зүйлийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй 6 тээврийн хэрэгсэл тод өнгийн дэвсгэр бүхий улсын дугаар хэрэглээгүй зөрчил илэрлээ.

*Хүснэгт № 2*

| № | Байгууллагын нэр | Машины марк | Улсын дугаар |
|---|---|---|---|
| 1 | Татварын хэлтэс | Ланд 200 | 3070 ХӨҮ |
| 2 | | Королла | 3320 ХӨҮ |
| 3 | Аймгийн ИТХ | Соната 8 | 0056 ХӨВ |
| 4 | Мөрөн сум | Приус 20 | 6145 ХӨҮ |
| 5 | Хөвсгөл Эрчим хүч ХХК | Ланд 200 | 1112 ХӨА |
| 6 | Шүүхийн Тамгын газар | KIA KB | 0004 ХӨН |

Нийт 5 байгууллагын 6 автомашин Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 “*Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ*” хэсэгт заасны дагуу тод өнгө бүхий улсын дугаар хэрэглээгүй зөрчлийг аудитын хугацаанд бүрэн арилгаж, автомашинуудыг хөх өнгийн улсын дугаартай болгосон байна.

2. Томилолтын удирдамж, холбогдох анхан шатны баримтаар нотлогдохгүй шатахуун зарцуулсан 9.8 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

- Дэлгэрмөрөн Шишхэд голын сав газрын захиргаа 5.0 сая төгрөг
- Биеийн тамир спортын хороо 0.9 сая төгрөг
- Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар 3.8 сая төгрөг

Дээрх зөрчил нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3. “*Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно*” гэсэн заалттай нийцэхгүй байгаа тул **Төлбөрийн акт** тогтоохоор шийдвэрлэлээ.

3. Байгууллагын төсвөөс 5.2 сая төгрөгөөр албан хэрэгцээнд шаардлагагүй ижил төрлийн хувцас болон биеийн тамирын хувцас худалдан авсан байна. Үүнд:

- Ханх сумын эрүүл мэндийн төв нь нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас 1.3 сая төгрөгөөр албан хаагчдад биеийн тамирын хувцас худалдан авсан,
- Мөрөн сумын 6 дугаар цэцэрлэг нь нөхөн хангалтын зардлаас 2.8 сая төгрөгөөр албан хаагчдад албан хэрэгцээнд шаардлагагүй, ижил төрлийн хувцас хэрэглэл худалдан авсан,
- Байгаль орчны газар 1.1 сая төгрөгөөр биеийн тамирын өмсгөл бэлтгэсэн байна.

Эдгээр зөрчил нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 “*Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно*” дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байгаа тул **төлбөрийн акт** тогтоохоор шийдвэрлэлээ.

*Авто машин ашиглах эрхгүй албан хаагчид автомашин ашигласан, хувцас хэрэглэл худалдан авсан, томилолт, тэтгэмжийг илүү дүнгээр олгосон зэрэг 158.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь төсөв захирагч, нягтлан бодогч, дотоод хяналтын нэгжийн хариуцлагагүй байдал, байгууллагын албан хаагчид уг хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа хангалтгүй байгаатай холбоотой байна.*

### *А.2. Төсвийн байгууллага, орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд хэмнэлтийн бусад арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулаагүй, хуулиар хориглосон зүйлсэд 98.6 сая төгрөгийн төсвийг зарцуулсан зэргээс харахад удирдлагын түвшинд хариуцлагын тогтолцоо алдагдсаныг харуулж байна.*

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлд төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хориглох зүйлс болон хэмнэлтийн горимын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай заасан байна. Тус зүйл заалттай холбоотой өмнөх аудитуудаар 435.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

*Хүснэгт № 3* */сая төгрөгөөр/*

| № | Хуулийн заалт | Дүн | Тайлбар |
|---|---|---|---|
| 1 | 15.1.3 | 123.2 | ИТХ-д суудалтай улс төрийн намд дэмжлэг олгосон, хууль журамд заагаагүй урамшуулал дэмжлэг олгосон, хандив өгсөн зэрэг зөрчил илэрсэн. |
| 2 | 15.1.4 | 1.5 | Спортын арга хэмжээний контент бэлтгэсэн. |
| 3 | 15.1.5 | 63.2 | Төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл бэлтгэсэн. |
| 4 | 15.1.6 | 83.5 | Хугацаа дууссан болон шаардлагагүй бараа материал бэлтгэж нөөцөлсөн. |
| 5 | 15.1.7 | 60.8 | Төсвийн хөрөнгөөр согтууруулах ундааны зүйлс бэлтгэсэн. |
| 6 | 15.2.1 | 8.5 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажиллаагүй. |
| 7 | 15.2.3 | 94.6 | Сургалт зөвлөгөөний үйл ажиллагаа зохион байгуулахдаа хэмнэлттэй байх горимыг баримтлаагүй. |
| | **НИЙТ** | **435.3** | |

Аудитаар хуулийн 15 дугаар зүйлтэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. *Үүнд:*

1. Биеийн тамир, спортын газрын даргад тушаал шийдвэргүйгээр 0.7 сая төгрөгийн урамшуулал бодож олгосон байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3 “*хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох*” гэсэн заалттай нийцэхгүй байгаа тул **төлбөрийн акт** тогтоохоор шийдвэрлэсэн.

2. Төсвийн хөрөнгөөр байгууллагад шаардлагагүй зүйлс бэлтгэж төсвийн үр ашгийг бууруулсан 97.9 сая төгрөгийн зөрчил 38 байгууллага дээр илэрлээ. Байгууллага тус бүрээр зөрчлийн дэлгэрэнгүй жагсаалтыг хавсралт 2-оор харуулав. Үүнд:

- Байгууллагын төсвөөс 14.2 сая төгрөгөөр бэлэг дурсгалын зүйлс бэлтгэж, зарцуулсан
- Байгууллагын үйл ажиллагаанд хэрэгцээ шаардлагагүй, үр ашиггүй 54.4 сая төгрөгийн бараа материал бэлтгэсэн
- Төсвийн хөрөнгөөр 29.3 сая төгрөгийн согтууруулах ундаа худалдан авсан байна.

Дээрх зөрчил нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 “*төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах*”, 15.1.6 “*нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх*”, 15.1.7 “*байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах*” гэсэн заалтуудтай нийцэхгүй байгаа тул **Төлбөрийн акт** тогтоохоор шийдвэрлэсэн.

3. Ерөнхий боловсролын сургуулиудын хүнсний материалын үлдэгдлийг 2024 оны жилийн эцсийн байдлаар хянаж үзэхэд материал нөөцөлсөн зөрчил нийтлэг байна. ***Тухайлбал:***

*Хүснэгт № 4*

| Сургуулийн нэр | Материалын нэр | Х.н | Эхний үлдэгдэл | Орлого | Зарлага | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|---|---|
| Арбулаг ЕБС | Хонины мах | Кг | 2,458.9 | 2,649.0 | 2,974.3 | 2,133.4 |
| | Үхрийн мах | Кг | 1,839.5 | 2,904.0 | 2,625.8 | 2,117.0 |
| | Гурил | Кг | 1,650.0 | 5,850.0 | 3,850.0 | 3,650.0 |
| Ханх ЕБС | Цагаан будаа | Кг | 1,506.6 | 0.0 | 625.5 | 881.1 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Цагаан-Үүр ЕБС | Гурил | Кг | 1,646.0 | 8,405.0 | 5,333.7 | 4,717.3 |
| | Цагаан будаа | Кг | 129.8 | 2,267.9 | 1,303.9 | 1,093.8 |
| Жаргалант ЕБС | Мах | Кг | 3,914.3 | 5,922.9 | 5,537.1 | 4,300.1 |
| | Гурил | Кг | 2,190.3 | 5,821.5 | 3,454.5 | 4,557.3 |
| | Будаа | Кг | 1,954.3 | 2,597.3 | 1,567.2 | 2,984.5 |
| | Гоймон | Кг | 217.6 | 2,990.7 | 524.9 | 2,683.4 |

*Эх сурвалж: Байгууллагуудын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан*

Хүснэгтээс харахад ЕБС-ууд нь хүүхдийн тоонд үндэслэж, бодит тооцоо хийхгүйгээр хүнсний материалыг хэт ихээр нөөцөлсөн харагдаж байна. Зарим материал нь дараагийн 2-3 жилд хангалттай хүрэлцэх үлдэгдэлтэй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 “*нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх*” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Материалыг хэт ихээр нөөцөлдөг асуудал нь ихэнх сургуулиуд дээр нийтлэг байдалтай байгаа тул аймгийн Боловсролын газарт тус асуудалд нэгдсэн байдлаар хяналт хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

4. Сумдын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын үлдэгдэлд бүтэн жилийн турш хөдөлгөөн хийгдээгүй, хугацаа дууссан эмийг бүртгэлд тусгасан 26.0 сая төгрөгийн 12 зөрчил илэрсэн байна. Тус зөрчилд нэгдсэн байдлаар хяналт хэрэгжүүлж, үр дүнг тайлагнаж ажиллах зөвлөмжийг аймгийн Эрүүл мэндийн газарт хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

5. Аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 45,941.2 сая төгрөгийн өр төлбөр бүртгэгдсэнээс 34,904.3 сая төгрөг нь орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өр төлбөрийн үлдэгдэл байна. Үүнээс 97 хувь нь Могойн гол ХК, Хөвсгөл Ус суваг ХХК, Хөвсгөл Эрчим хүч ХХК-тай холбоотой байна. Өр төлбөрийг хэрхэн барагдуулах талаар орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн ТУЗ болон гүйцэтгэх удирдлагаас бодлогын шинжтэй арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй, ямар хугацаанд барагдуулах талаар тооцоолол, ажлын төлөвлөгөөг гаргаж ажиллахгүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5 “*хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх*” гэсэн заалттай нийцэхгүй байна.

6. Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 13 дугаар тогтоолоор орон нутгийн өмчит компаниудын 2024 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшнийг баталсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

*Хүснэгт № 5* */сая төгрөгөөр/*

| № | Нэр | Анх баталсан ашиг/алдагдал | Гүйцэтгэлээр ашиг/алдагдал |
|---|---|---|---|
| **1** | Хөвсгөл Эрчим хүч ХХК | (548.4) | 403.8 |
| **2** | Хөвсгөл Ус суваг ХХК | (870.0) | (314.8) |
| **3** | Шинэ мөрөн худалдааны төв ХХК | (165.5) | (176.5) |
| **4** | Хөдөөгийн шийдэл ХХК | 45.4 | (104.2) |
| **5** | Мөрөн Хот тохижилт үйлчилгээний төв ХХК | (300.0) | (80.9) |
| **6** | Их-Уул дулаан ХХК | 1.0 | 1.9 |
| **7** | Тариалан НАҮТ ХХК | 1.9 | (29.6) |
| **8** | Тосон-Илч ХХК | 10.0 | (51.7) |
| **9** | Түнэл-Илч ХХК | 31.9 | (58.8) |
| **10** | Тэсийн-Илч ХХК | (461.0) | (312.9) |
| **11** | Шинэ-Идэр эрдэнэт дулаан ХХК | 0.2 | (107.1) |
| **12** | Галт дулаан ХХК | (173.5) | (89.6) |
| **ТУЗ-ын 2024 оны 09 дүгээр тогтоолоор** | | | |
| 13 | Могойн гол ХК | 2,300.40 | -991.6 |

*Эх сурвалж: Байгууллагуудын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан*

Хүснэгтээс харахад 7 аж ахуйн нэгжийн зорилтот түвшнийг нийт 2,390.8 сая төгрөгийн ашигтай, 6 аж ахуйн нэгжийн зорилтот түвшнийг нийт 2,518.4 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар баталжээ. Гүйцэтгэлээр 2 аж ахуйн нэгж нийт 405.7 сая төгрөгийн ашигтай, 11 аж ахуйн нэгж 2,317.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Үүнээс: Могойн гол ХК 991.6 сая төгрөг, Хөвсгөл ус суваг ХХК 314.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан нь анхаарал татаж байна. Компанийн нөөц бололцоог бүрэн дайчлах, үр ашигтай ажиллуулах нэгдсэн бодлогоор хангахгүй байгаа нь компаниуд баталсан төлөвлөгөөг биелүүлэхээр зорьж ажиллахгүй, ажилласан гүйцэтгэлдээ тохируулж төлөвлөгөөг баталдаг, орон нутагт төвлөрүүлэх татварын орлогыг тодорхой хэмжээнд бууруулдаг зэрэг сөрөг үр дагаврууды бий болгож байна.

Аймгийн ИТХ-аас өмчийн төлөөллийг хэрэгжүүлэхээр Компанийн тухай хуулийн дагуу орон нутгийн өмчит компаниудад Төлөөлөн Удирдах Зөвлөлийг томилсон байна.

Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдээс томоохон аж ахуйн нэгжүүдийг түүвэрлэн ТУЗ-ын дарга болон гишүүдийн цалин хөлсийг харьцуулан харуулбал дараах байдалтай байна.

*Хүснэгт № 6* */сая төгрөгөөр/*

| № | Аж ахуйн нэгжийн нэр | ТУЗ-ийн гишүүний тоо | ТУЗ-ын даргын сарын цалин | ТУЗ-ийн гишүүдийн сарын цалин | ТУЗ-ийн нарийн бичгийн даргын сарын цалин | Жилийн ТУЗ-ын цалин хөлсний дүн | Бусад зардал | ТУЗ-ийн жилийн нийт зардал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Хөвсгөл Эрчим хүч ХХК | 9 | 0.6 | 0.6 | 1.1 | 73.8 | 21.5 | 95.3 |
| 2 | Хөвсгөл Ус суваг ХХК | 9 | 0.3 | 0.3 | 0.9 | 37.9 | 5.1 | 43.0 |
| 3 | Могойн гол ХК | 9 | 2.5 | 2.5 | 2.2 | 296.4 | 189.5 | 485.9 |
| 4 | Шинэ мөрөн ХҮТ ХХК | 9 | 0.3 | 0.3 | 1.1 | 40.2 | 6.0 | 46.2 |
| 5 | Хөдөөгийн шийдэл ХХК | 9 | 0.2 | 0.2 | 0.7 | 29.5 | 5.5 | 35.0 |

*Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын 2024 оны 4 сарын 25-ны өдрийн ТУЗ-ийн зардал батлах тухай XXVI/20 дугаар тогтоол*

Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд нь жил дараалан үр ашиггүй ажилласан, ТУЗ нь аж ахуйн нэгжийг үр ашигтай ажиллуулах талаар бодитой арга хэмжээ авч ажиллаагүй байхад ажлын ачаалал, үр дүнг харгалзахгүйгээр ТУЗ-ийн цалин хөлсөнд жилд 29.5-296.4 сая хүртэл төгрөгийг олгож байгаа нь үр ашиггүй зардлын нэмэгдүүлсэн байна.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн бүтэц орон тоог гүйцэтгэл, үр ашигтай уялдуулан оновчтой байдлаар тодорхойлоогүй байна. ***Тухайлбал:*** Могойн гол ХК- ний орон тоог 2021-2024 онд 88-181 болгож 93 орон тоог нэмэгдүүлсэн, Хөвсгөл Эрчим хүч ХХК-ийн орон тоог 2022-2024 онд 7 удаагийн тогтоолоор 115-122 орон тоотой байхаар өөрчилж тогтоосон байна.

Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой компаниудыг үр ашигтай ажиллуулах нэгдсэн бодлогоор хангаагүй, ТУЗ-ийн цалин хөлсийг үр ашигтай уялдуулан тогтоодоггүй, компанийн бүтэц орон тоог оновчтой төлөвлөхгүй байгаа зөрчлүүд нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 “*Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшинийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно*”, 15 дугаар зүйлийн 15.2.6 “*байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох*” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

*Орон нутгийн өмчит компаниудыг үр ашигтай ажиллуулах нэгдсэн бодлогоор хангаагүй, чиг үүрэг, бүтэц орон тоог үр ашиг, үр дүнтэй уялдуулан тогтоогоогүй, хуулиар хориглосон зүйлсэд 98.6 сая төгрөгийн төсвийг зарцуулсан зэргээс харахад удирдлагын түвшинд хариуцлагын тогтолцоо алдагдсаныг харуулж байна.*

**Бүлэг 2: *Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний 56 хувь нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахгүй байна.***

### *Б.1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний 56 хувь нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахгүй байна.*

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн хөрөнгө оруулалт, Замын сан, Их засварын хөрөнгөөр 2023 онд 8,930.8 сая төгрөгийн 84 төсөл арга хэмжээ, 2024 онд 19,738.6 сая төгрөгийн 113 төсөл арга хэмжээ, 2025 онд 51,802.3 сая төгрөгийн 44 төсөл арга хэмжээг тус тус хэрэгжүүлэхээр аймгийн ИТХ-аас баталсан байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөж баталсан төсөл арга хэмжээнүүдийг Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцсэн эсэхийг хянахад дараах байдалтай байна. Үүнд:

*Хүснэгт № 7* */сая төгрөгөөр/*

| ТАХ-г хэрэгжүүлж эхэлсэн он | Хэрэгжүүлэхээр баталсан ТАХ | | Үүнээс ТХТХ-ийн 13.3.3 дахь заалтыг зөрчсөн | | | Үүнээс ТХТХ-ийн 13.3.2 дахь заалтыг зөрчсөн | | | Тендерийн хэмнэлт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Төсөвт өртөг | Тоо | Төсөвт өртөг | Хувь | Тоо | Төсөвт өртөг | Хувь | |
| **2023** | 84 | 8,930.8 | 40 | 3,892.4 | 48% | 3 | 330.0 | 2% | 376.9 |
| **2024** | 113 | 19,738.6 | 72 | 7,773.7 | 64% | 2 | 29.0 | 2% | 325.5 |
| **2025** | 44 | 51,802.3 | 23 | 43,071.3 | 52% | 0 | 0.0 | | - |
| **ДҮН** | **241** | **80,471.7** | **135** | **54,737.4** | **56%** | **5** | **359.0** | **2%** | **702.4** |

Аймгийн ОНХО, ОНХС, Замын сан, Их засварын хөрөнгөөр Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3 дахь заалттай нийцэхгүй буюу зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл хийгдээгүй 54,737.4 сая төгрөгийн 135 төсөл арга хэмжээ, хуулийн 13.3.2 дахь хэсэгт нийцэхгүй буюу орон нутгийн өмчлөлд бүртгэх боломжгүй 109.0 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Тус зөрчилд Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын гүйцэтгэсэн 2023, 2024, 2025 оны орон нутгийн төсвийн төсөлд санал дүгнэлт гаргах аудитуудаар 1 албан шаардлага, 6 зөвлөмжийг хүргүүлж ажилласан ч үр дүнд тодорхой ахиц гарахгүй байна.

***Сумдын ОНХС, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний тухайд:***

- Мөрөн сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд 777.0 сая төгрөгийн зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлгүй 8 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна. Энэ нь Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3 *“техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ”* гэсэн заалттай нийцэхгүй байгаа тул “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” аудитаар албан шаардлага хүргүүлсэн байна.
- Мөрөн сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 111.5 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээ нь орон нутгийн өмчлөлд бүртгэх боломжгүй, 845.4 сая төгрөгийн 23 төсөл арга хэмжээ нь зураг төсөвгүй байна. Мөрөн сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд 32.8 сая төгрөгийг хэмнэсэн ба тус хэмнэлтийг 2024 оны төсвийн тодотголоор шинээр хэрэгжих төсөл арга хэмжээний санхүүжилтээр баталсан байна. Эдгээр зөрчилд “Улс болон орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт” гүйцэтгэлийн аудитаар зөвлөмж хүргүүлсэн байна.
- Тариалан, Тосонцэнгэл сумдын 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр иргэдийн саналаар дэмжигдээгүй 162.4 сая төгрөгийн төсөл арга хэмжээг баталж хэрэгжүүлсэн зөрчлүүд илэрсэн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 “*Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан,*

*хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ”* гэсэн заалттай нийцэхгүй байгаа зөрчилд “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” аудитаар зөвлөмж хүргүүлсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1 *“хөшөө, дурсгал, орон нутгийн угтах, үдэх хаалга барьж байгуулах”* заалтын хэрэгжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Жаргалант сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2022 онд 21.2 сая төгрөгөөр хилийн цэс, хаалга барьсан.
- Рэнчинлхүмбэ сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд 9.0 сая төгрөгөөр угтах, үдэх хаалга барьсан,
- Төмөрбулаг сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд 34.3 сая төгрөгөөр угтах, үдэх хаалга барьсан байна.

Тус зөрчлүүдэд санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага хүргүүлж, зөрчлийг таслан зогсоосон болно.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж баталсан зарим төсөл арга хэмжээний төсөвт өртгийг нэмэгдүүлж баталсан байна. Үүнд:

*Хүснэгт № 8* */сая төгрөгөөр/*

| № | Хөрөнгө оруулалтын төрөл | Он | ТАХ-ы тоо | Анх баталсан төсөвт өртөг | Нэмэгдүүлсэн төсөвт өртөг | Нийт төсөвт өртөг |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Аймгийн ОНХС | 2022 | 4 | 480.0 | 689.1 | 1,169.1 |
| 2 | ОНХО | 2022 | 3 | 391.0 | 418.5 | 809.4 |
| 3 | Аймгийн ОНХС | 2023 | 4 | 386.5 | 224.2 | 610.7 |
| 4 | Их засвар | 2023 | 4 | 540.0 | 491.9 | 1,031.9 |
| 5 | Аймгийн ОНХС | 2024 | 8 | 2,695.2 | 2,073.7 | 4,768.9 |
| 6 | Их засвар | 2024 | 3 | 504.7 | 499.6 | 1,004.3 |
| 7 | Замын сан | 2024 | 5 | 1,198.3 | 1,055.8 | 2,254.2 |
| | **НИЙТ** | | **31** | **6,195.7** | **5,452.9** | **11,648.5** |

*Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын 2022-2024 оны төсвийн тогтоолууд*

Аймгийн ИТХ-аар хэлэлцэж баталсан 6,195.7 сая төгрөгийн 31 төсөл арга хэмжээний төсөвт өртгийг 5,452.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж 11,648.5 сая төгрөг болгож баталсан нь зураг төсөвгүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталдагтай холбоотой байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.5 “*Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хуулиар батлагдсанаас хойш түүний төсөвт өртөг нэмэгдүүлэх үр дагавар бүхий нэмэлт шаардлагыг зохиогч, ашиглагч, захиалагчийн хяналт тавих этгээд гаргахгүй байх”* гэсэн заалттай нийцэхгүй байна.

*Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2022-2024 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний 56 хувь нь хуулийн шаардлага хангаагүй, төсвийг 46.8 хувиар нэмэгдүүлсэн зэргээс харахад төсөл арга хэмжээг анх төлөвлөхдөө төсөвлөлтийн шаардлага хангахгүйгээр баталж хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.*

### ***Б.2. Цахим дэлгүүрийн барааны үнэ өндөр, чанар хангалтгүй, бүтээгдэхүүний тоо хэмжээний хувьд хязгаарлагдмал байна.***

Хөвсгөл аймгийн хэмжээнд Төрийн цахим дэлгүүрээс 2022-2024 онд нийт 12,632.7 сая төгрөгийн худалдан авалтыг хийсэн байна.

*Хүснэгт № 9* */сая төгрөгөөр/*

| № | Салбар | 2022 он | 2023 он | 2024 он | Нийт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Боловсролын байгууллагууд | 2,675.3 | 6,392.0 | 178.5 | **9,245.8** |
| 2 | Эрүүл мэндийн байгууллагууд | 378.4 | 1,229.0 | 1,534.9 | **3,142.3** |
| 3 | Бусад байгууллагууд | **2.6** | **9.9** | **232.1** | **244.6** |
| | **Нийт цахим худалдан авалт** | **3,056.3** | **7,630.9** | **1,945.5** | **12,632.7** |

*Эх сурвалж: Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем*

Төрийн цахим дэлгүүрээс эрүүл мэндийн байгууллагууд эмийн худалдан авалт, боловсролын байгууллагууд цахим анги, утасгүй интернэт, тоног төхөөрөмж, бусад төрийн захиргааны байгууллагууд компьютер, хэвлэгч тоног төхөөрөмжүүдийг ерөнхий гэрээний аргаар худалдан авсан байна.

Цахим дэлгүүрээс худалдан авалт хийх нь цаг хугацаа, худалдан авах ажиллагаатай холбоотой бусад зардлыг хэмнэх, ашиг сонирхлын зөрчил гарахгүй байх сайн талтай болovч дараах сөрөг үр дагавруудыг үүсэж байна. Үүнд:

1. Зах зээлийн үнээс өндөр. ***Тухайлбал:*** ухаалаг дэлгэц 65"-ийг цахим дэлгүүрээс 9.8 сая төгрөгөөр худалдан авдаг бол зах зээлээс дээрх үзүүлэлттэй ухаалаг дэлгэцийг 6.5-7.0 сая төгрөгт худалдан авах боломжтой байна.
2. Ижил төрлийн барааг олон байгууллагууд зэрэг захиалах үед тоо хүрдэггүй, хугацааны хувьд хүлээлт бий болдог.
3. Зарим бараа нь чанарын шаардлага хангалтгүй, цахим дэлгүүрт байршуулсан барааны зураг, бодит байдал ялгаатай байдаг. ***Тухайлбал:*** Сурагчийн ширээ сандлыг цахим дэлгүүрээс 0.6 сая төгрөгөөр худалдан авч байхад орон нутгийн модны үйлдвэрт цэвэр модон ширээ сандлыг 0.3 сая төгрөгөөр нийлүүлэх боломжтой байна.
4. Нэр төрөл цөөн, сонголт багатай.
5. Эдийн засгийн эргэлт нь орон нутагт үлдэхгүй байх талтай.

Цахим дэлгүүрээс хийсэн худалдан авалтын 73 хувийг боловсролын салбарын байгууллагууд хийсэн байна. Үүнд аймгийн хэмжээнд боловсролын шинэчлэлийг дэмжих зорилготой цахим анги, утасгүй интернэтийн төхөөрөмж худалдан авахад нийт 5,775.4 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан нь голлох нөлөөг үзүүлсэн байна.




Үүнээс 706.2 сая төгрөгийн утасгүй интернэт нь чанарын шаардлага хангахгүй, интернэтийн хурд муу гэсэн шалтгаанаар бүрэн ашиглагдахгүй, тухайн хөрөнгөд зарцуулсан төсвийн үр дүн хангалтгүй байна. Харин цахим ангид хийсэн хөрөнгө оруулалт нь бүх сургуулиудад бүрэн ашиглагдаж байна.

Аймгийн Худалдан авах ажиллагааны алба нь Төрийн цахим дэлгүүрт аж ахуйн нэгж байгууллагуудын нэгдэх хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх чиг үүрэгтэй байгаа боловч 2022 оноос хойш нэг ч хүсэлт ирээгүй байна.

Орон нутгийн өмчийн оролцоотой болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн худалдан авах ажиллагааг төлөвлөхдөө тендер шалгаруулалтын босго үнээс зайлсхийж ижил төрлийн бараа ажил үйлчилгээний төсөвт өртгийг хувааж төлөвлөдөг нийтлэг зөрчил байна. ***Тухайлбал:***

a. Хөвсгөл Эрчим хүч ХХК нь 2023 онд Ханх сумын ЦДАШ-ын шинэчлэлийн ажилд шаардлагатай 160.5 сая төгрөгийн бараа материалын төсөвт өртгийг 49.0 сая төгрөг, 47.4 сая төгрөг, 64.1 сая төгрөгөөр 3 хэсэгт хувааж харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Эдгээр 3 тендерийг 1 компани бэлтгэн нийлүүлэхээр гэрээ байгуулсан байна. Мөн 2024 онд цахилгааны материал худалдан авах тендерийг нээлттэй тендер шалгаруулалтын босго үнээс 0.2 сая төгрөгөөр доогуур буюу 99.8 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.
b. Хөвсгөл Ус Суваг ХХК нь 2023 онд смарт худаг усан сангийн тендерийг харьцуулалтын аргаас зайлсхийж 20.7 сая төгрөгийн төсөвт өртгийг 9.3 сая төгрөг, 11.5 сая төгрөгөөр хувааж шууд гэрээ байгуулсан, 2024 онд багаж хэрэгсэл,

засварын материалуудын төсөвт өртгийг 5 хэсэгт хуваах, харьцуулалтын болон шууд худалдан авалтын аргаар нэг бэлтгэн нийлүүлэгчээс худалдан авсан байна.

c. Могойн гол ХК нь 2024 онд ЭКГ-5А цахилгаан экскаваторын 280.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй сэлбэг хэрэгслийн тендерийг нээлттэй тендер шалгаруулалтын босго үнээс зайлсхийж 100.0 сая төгрөгөөс багаар 3 хувааж, харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулж 1 бэлтгэн нийлүүлэгчтэй гэрээ байгуулсан байна.

Эдгээр зөрчил нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.5 “*Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана*”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 “*Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно*” гэсэн заалттай нийцэхгүй байна.

*Цахим дэлгүүрийн барааны үнэ өндөр, чанар хангалтгүй, бүтээгдэхүүний тоо хэмжээний хувьд хязгаарлагдмал байгаа нь тухайн худалдан авалтад зарцуулсан төсвийн үр дүнг бууруулах, босго үнээс зайлсхийж төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулж байгаа нь ашиг сонирхолтой байж болзошгүй эрсдэлийг дагуулж байна.*

## ***Бүлэг 3: Төсвийн хэмнэлтийг 2022-2024 онд нийт батлагдсан төсөвтэй харьцуулахад 1.2 орчим хувийг хэмнэсэн байгаагаас харахад сүүлийн жилүүдэд тус хуулийн хэрэгжилтэд тодорхой ахиц гаргахгүй байгааг харуулж байна.***

### ***В.1. 2022-2024 онд тус хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил дутагдал нэмэгдсэн нь хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагаас хуулийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүйг харуулж байна.***

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 19 дүгээр зүйл заалтад зааснаар аймаг, сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс, аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба , орон нутгийн өмчит компаниудын Төлөөлөн удирдах зөвлөл, Аудитын хорооноос хяналт тавьж ажиллах чиг үүрэгтэй байна.

***Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба:*** Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь Аймгийн Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын хороогоор төлөвлөгөөгөө батлуулж 2023 онд 9 дотоод аудит, 53 төлөвлөгөөт санхүүгийн хяналт шалгалт, 11 төлөвлөгөөт бус хяналт, 2024 онд 110 байгууллагад тус тус хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Санхүүгийн хяналт, аудитын албаны хийсэн хяналтаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 103.2 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 9.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 94.2 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж ажилласан байна.

***Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс:*** Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсээс дотоод хяналт, төлбөр тооцооны мэргэжилтнүүд нь зарлагын гүйлгээ гаргахдаа хуулийн хориглосон заалттай холбоотой эсэхэд хяналт хэрэгжүүлдэг байна. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчлийг нэгтгэн тусгаж, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлж үр дүнг тооцох зөвлөмжийг хүргүүлсэн ч хэрэгжилт хангалтгүй, хэмнэлтийн арга хэмжээний талаар хэрэгжүүлсэн ажил байхгүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 “*хэмнэлтийн арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх асуудлаар санал боловсруулж, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх*” гэсэн заалттай нийцэхгүй байна.

***Орон нутгийн өмчит компаниудын ТУЗ, Аудитын хороо:*** Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн Төлөөлөн Удирдах зөвлөл, түүний Аудитын хорооноос Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хангамж, үйл ажиллагааны хязгаарлалт, үр ашигтай байх байдалд хийсэн хяналт байхгүй, Компаниудын ТУЗ-ийн аудитын хороо нь 2022-2024 онд огт хуралдаагүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 19.2 “*Төрийн болон орон*

*нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан энэ хуульд заасан хангамж, үйл ажиллагааны хязгаарлалтыг чанд мөрдөх ажилд хяналт тавьж, удирдах ажлыг хэрэгжүүлнэ”* гэсэн заалттай нийцэхгүй байна.

*Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил жил бүр нэмэгдсээр байгаа нь хяналтын чиг үүрэг бүхий байгууллага, удирдах албан тушаалтнуудын хяналт хангалтгүй байгааг харуулж байна.*

### *B.2. Төсвийн хэмнэлтийг 2022-2024 онд нийт батлагдсан төсөвтэй харьцуулахад 1.2 орчим хувийг хэмнэсэн байгаагаас харахад сүүлийн жилүүдэд тус хуулийн хэрэгжилтэд тодорхой ахиц гаргахгүй байгааг харуулж байна.*

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2022-2024 онд нийт 260,081.9 сая төгрөгийн төсвийг захиран зарцуулсан байна.

*Хүснэгт № 10* */сая төгрөгөөр/*

| Тайлант он | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Зарцуулаагүй үлдэгдэл | Үүнээс: Хэмнэлт | хувь |
|---|---|---|---|---|---|
| **2022** | 68,462.5 | 59,305.2 | 9,157.4 | 929.7 | **1.5%** |
| **2023** | 84,075.3 | 72,312.3 | 11,763.0 | 1,137.0 | **1.4%** |
| **2024** | 107,544.1 | 98,406.7 | 9,137.4 | 1,019.0 | **1.0%** |
| **НИЙТ** | **260,081.9** | **230,024.1** | **30,057.8** | **3,085.7** | **1.2%** |

*Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2022, 2023, 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан*

Хүснэгтээс харахад 2022-2024 онд нийт төсвөөс 30,057.8 сая төгрөгийг зарцуулаагүй байна. Энэ нь төсвийг бодит тооцоо судалгаанд үндэслэн үр ашигтай байхаар төлөвлөдөггүйтэй холбоотой байна. Тус зөрчил нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3. *“үр ашигтай байх”,* 4.1.7. “*бодитой байх*”, 18 дугаар зүйлийн 18.1.3 “*хэмнэлтийн горимыг чанд мөрдөх үйл ажиллагааны төлөвлөлт, уялдаа холбоо, зохицуулалтыг удирдлагаар хангах, энэ талаар тухайн жилийн төсөв боловсруулах удирдамжид тусгаж, төсвийн ерөнхийлөн захирагчдад хүргүүлэх*” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Хэмнэсэн зардлыг зардлын ангилал, хуулийн холбогдох заалттай нийцүүлэн харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

*Хүснэгт № 11* */сая төгрөгөөр/*

| Хуулийн холбогдох заалт | Хэмнэсэн зардал | | | | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| | 2022 | 2023 | 2024 | Нийт | |
| **ТХТХ-8.1.** | 0 | 5.1 | 1.8 | 6.9 | Нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас хэмнэсэн байна. |
| **ТХТХ-12.1.3.** | 2.1 | 3.1 | 3.4 | 8.6 | Ном хэвлэлийн зардлаас зарцуулалт хийхгүйгээр хэмнэсэн байна. |
| **ТХТХ-15.2.1.** | 2.1 | 8.6 | 51.7 | 62.4 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас хэмнэсэн. |
| **ТХТХ- 15.2.3 /15.2.7/.** | 37.4 | 20.9 | 13.9 | 72.2 | Сургалт, зөвлөгөөний зарим үйл ажиллагааг цахимаар явуулснаас тээвэр шатахуун, дотоод албан томилолт, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлуудыг хэмнэсэн. |
| **ТХТХ-15.2.4** | 4.6 | 9.1 | 13.6 | 27.3 | ERP системийн хэрэгжилттэй холбоотой бичиг хэрэг, шуудан холбооны зардлаас хэмнэсэн. |
| **ТХТХ-15.2.6.** | 183.3 | 235.1 | 377.5 | 795.9 | Цалин хөлс, нийгмийн даатгалын зардлаас хэмнэсэн. |
| **ТХТХ-13.1.3** | 700.3 | 855.1 | 557 | 2,112.4 | Аймаг сумын ОНХС, ОНХО, Замын сан, Их засвар, БХНСАХ-ний хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний тендерийн хэмнэлт |
| **НИЙТ** | **929.8** | **1,137.0** | **1,018.9** | **3,085.7** | |

Хүснэгтээс харахад 2024 оны төсвийн хэмнэлтийг 2022 оны төсвийн хэмнэлттэй харьцуулахад 89.1 сая төгрөг буюу 8.7 хувиар нэмэгдсэн, 2022-2024 онд нийт батлагдсан

төсөвтэй харьцуулахад 1.2 орчим хувийг хэмнэсэн байгаагаас харахад сүүлийн жилүүдэд тус хуулийн хэрэгжилтэд тодорхой ахиц гаргахгүй байгааг харуулж байна.

Аудитаар 2022-2024 онд төсвийг зориулалт бусаар зарцуулсантай холбоотой 437.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс харахад мөн хэмжээний хэмнэлт хийж ажиллах боломжийг алдсан байна.

*Төсвийг төлөвлөхдөө бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөдөггүйгээс нийт төсвийн 10 орчим хувийг зарцуулахгүй үлддэг, төсвийн хэмнэлтийг* 2022-2024 онд нийт батлагдсан төсөвтэй харьцуулахад 1.2 орчим хувийг хэмнэсэн байгаагаас харахад сүүлийн жилүүдэд тус хуулийн хэрэгжилтэд тодорхой ахиц гаргахгүй байгааг харуулж байна.

### В.3. Мэдээллийн ил тод байдал хангалтгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д хуулийн үйлчлэлд хамаарах этгээдүүд нь Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулж ил тод байдлыг хангаж ажиллах талаар заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг жил бүр хянаж ажилладаг. Сүүлийн 3 жилийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчлийг харуулбал:

*График №3*




Графикаас харахад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил жил бүр давтагдсаар байгаа ба хуулийг хэрэгжүүлж, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллахгүй байгаа нь дараах шалтгаантай байна. Үүнд:

1. Төсөв захирагч, нягтлан бодогч, Шилэн дансанд мэдээлэл оруулах бусад албан хаагчдын хариуцлагагүй байдал
2. Шилэн дансны цахим системээс хамаарч байна. ***Тухайлбал:*** нь зарим үед гацдаг, мэдээлэл хадгалагдахгүй зэрэг алдаа заадаг, хөгжүүлэлт бүрэн хийгдээгүй, мэдээлэл оруулах хугацаатай давхардуулан хөгжүүлэлт хийдэг
3. Шилэн дансны цахим хуудсанд ил тод мэдээлэх шаардлагатай зарим мэдээлэл бусад хуулийн заалттай зөрчилдсөний улмаас хугацаа хоцроож мэдээлдэг. Үүнд:
   - Төсвийн байгууллага болон ТБОНӨҮГ-уудын аудитын тайлан дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг жил бүрийн 7 дугаар сарын 1-ний өдрийн дотор мэдээлэхээр заасан боловч аудитын байгууллага нь шийдвэрийн хэрэгжилт тайлагнах хугацааг илэрсэн зөрчлөөс хамааруулан өөр өөрөөр тогтоодог.
   - Төрийн болон орон нутгийн өмчит газруудын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг сар бүрийн 8-ны дотор мэдээлэхээр заасан нь ТУЗ-ын хуралдаан, аймгийн ИТХ-ын хуралдааны хугацаанаас шалтгаалан хоцроох тохиолдлууд гарч байна.
   - Төрийн болон орон нутгийн өмчит газруудын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор мэдээлэхээр заасан нь ТУЗ-ын хуралдаанаас шалтгаалан хугацаа хоцорч мэдээлэх эрсдэлтэй байна.
   - Төрийн болон орон нутгийн өмчит газруудын Байгууллагын батлагдсан төсвийг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор мэдээлэхээр заасан нь мөн ТУЗ-ийн хурлаас хамаарч хугацаа хоцрох эрсдэлтэй байна.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь санхүүгийн үйл ажиллагааг Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэхээс гадна компанийн засаглалтай холбоотой ил тод, нээлттэй байршуулах мэдээллийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлд зааж өгсөн байна. Үүний дагуу төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн цахим хуудас дахь мэдээллүүдийг хяналт хэрэгжүүллээ.







Могойн гол ХК нь www.mogoingol.mn цахим сайттай, Хөвсгөл Эрчим хүч ХХК нь https://www.gov.mn/mn/ төрийн өмчит хуулийн этгээдийн нээлттэй мэдээллийн цахим хуудсанд 2025 оноос мэдээллээ оруулж эхэлсэн байна.













Бусад компаниуд нь фэйсбүүк хуудсаар мэдээллээ нээлттэй хүргэж байна. Цахим хуудсанд оруулсан мэдээллээс харахад компанийн өдөр тутмын үйл ажиллагаа, хүний нөөцийн ил тод байдалтай холбоотой мэдээллийг хүргэсэн бол компанийн засаглалтай холбоотой мэдээллийг бүх компаниуд огт мэдээлээгүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 20.3, 20.4 дэх заалттай нийцэхгүй байна.

*Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой тодорхой зөрчлүүд жил бүр давтагдан гардаг, компанийн засаглалтай холбоотой шийдвэрүүдийг мэдээлдэггүй нь мэдээллийн ил тод байдлын чанар үр дагаварт төдийлөн анхаарахгүй байгааг илтгэж байна.*

*Аудитаар 113.6 сая төгрөгийн зөрчилд 40 төлбөрийн акт тогтоож, 5,452.9 сая төгрөгийн зөрчилд 16 зөвлөмжийг хүргүүлж байна.*

## ДҮГНЭЛТ:

**Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.**

1. Авто машин ашиглах эрхгүй албан хаагчид автомашин ашигласан, хувцас хэрэглэл худалдан авсан, томилолт, тэтгэмжийг илүү дүнгээр олгосон зэрэг 158.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь төсөв захирагч, нягтлан бодогч, дотоод хяналтын нэгжийн хариуцлагагүй байдал, байгууллагын албан хаагчид уг хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа хангалтгүй байгаатай холбоотой байна.
2. Орон нутгийн өмчит компаниудыг үр ашигтай ажиллуулах нэгдсэн бодлогоор хангаагүй, чиг үүрэг, бүтэц орон тоог үр ашиг, үр дүнтэй уялдуулан тогтоогоогүй, хуулиар хориглосон зүйлсэд 98.6 сая төгрөгийн төсвийг зарцуулсан зэргээс харахад удирдлагын түвшинд хариуцлагын тогтолцоо алдагдсаныг харуулж байна.
3. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2022-2024 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний 56 хувь нь хуулийн шаардлага хангаагүй, төсвийг 46.8 хувиар нэмэгдүүлсэн зэргээс харахад төсөл арга хэмжээг анх төлөвлөхдөө төсөвлөлтийн шаардлага хангахгүйгээр баталж хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.
4. Цахим дэлгүүрийн барааны үнэ өндөр, чанар хангалтгүй, бүтээгдэхүүний тоо хэмжээний хувьд хязгаарлагдмал байгаа нь тухайн худалдан авалтад зарцуулсан төсвийн үр дүнг бууруулах, босго үнээс зайлсхийж төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулж байгаа нь ашиг сонирхолтой байж болзошгүй эрсдэлийг дагуулж байна
5. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил жил бүр нэмэгдсээр байгаа нь хяналтын чиг үүрэг бүхий байгууллага, удирдах албан тушаалтнуудын хяналт хангалтгүй байгааг харуулж байна.
6. Төсвийг төлөвлөхдөө бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөдөггүйгээс нийт төсвийн 10 орчим хувийг зарцуулахгүй үлддэг, төсвийн хэмнэлтийг 2022-2024 онд нийт батлагдсан төсөвтэй харьцуулахад 1.2 орчим хувийг хэмнэсэн байгаагаас харахад сүүлийн жилүүдэд тус хуулийн хэрэгжилтэд тодорхой ахиц гаргахгүй байгааг харуулж байна.
7. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой тодорхой зөрчлүүд жил бүр давтагдан гардаг, компанийн засаглалтай холбоотой шийдвэрүүдийг мэдээлдэггүй нь мэдээллийн ил тод байдлын чанар үр дагаварт төдийлөн анхаарахгүй байгааг илтгэж байна.

## ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

**Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга Д.Пүрэвдорж-д:**

1. Төсөл арга хэмжээг батлахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан холбогдох шаардлагад нийцүүлэх
2. Орон нутгийн өмчит компаниудыг үр ашигтай ажиллуулахад анхаарч, нэгдсэн бодлогоор хангаж ажиллах
3. Орон нутгийн өмчит компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин хөлсийг компанийн үр ашиг, ажлын гүйцэтгэл, үр дүнтэй уялдуулан тогтоох

**Хөвсгөл аймгийн Засаг дарга Л.Төмөрбаатар-т:**

4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хориглосон заалтад хамаарах зүйлд хөрөнгө зарцуулж, төсвийн үр ашгийг бууруулсан байгууллагын үйл ажиллагаанд анхаарч, дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллах
5. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төсвийн бүх үе шатанд тууштай баримтлан ажиллах

**Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Базардамбуу-д**

6. Төсөл арга хэмжээг төлөвлөхдөө Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан холбогдох шаардлагад нийцүүлэх

**Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Г.Базар-д**

7. Төсвийн төлөвлөлтийг хийхдээ бодит тооцоо судалгаанд үндэслэн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллах
8. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, төрийн сангийн хяналтыг эрчимжүүлэх

**Орон нутгийн өмчит компаниудын ТУЗ-д:**

9. Компанийг үр ашигтай ажиллуулах талаар санал санаачилга гаргаж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах
10. Компанийн хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг барагдуулах төлөвлөгөө хуваарийг батлах
11. Компанийн чиг үүрэг, бүтэц орон тоог үр ашигтай уялдуулан тогтоож, тууштай баримтлах

**Орон нутгийн өмчит компаниудын гүйцэтгэх захирлуудад:**

12. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах
13. Компанийн хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг барагдуулах төлөвлөгөө хуваарийг гаргаж, шийдвэрлүүлэх
14. Компанийн засаглалтай холбоотой Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан мэдээллийг ил тод мэдээлж ажиллах

**Аймгийн Боловсролын газрын дарга О.Бадраа-д**

15. ЕБС-уудын материалын үлдэгдэлд хяналт хэрэгжүүлж, үр дүнг тайлагнаж, зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллах

**Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга М.Үүрийнбаяр-д**

16. Сумдын ЭМТ-ийн эм, эмнэлгийн хэрэгслийн үлдэгдэлд хяналт хэрэгжүүлж, үр дүнг тайлагнаж, зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллах

## Зөрчлийн нэгтгэл

/Сая.төгрөг/

| № | Илэрсэн зөрчлийн | | Акт | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|
| | Утга | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Томилолтын удирдамж, холбогдох анхан шатны баримтаар нотлогдохгүй шатахуун зарцуулсан байна. | 9.8 | 40 | 9.8 | | |
| 2 | Байгууллагын төсвөөс 5.2 сая төгрөгөөр албан хэрэгцээнд шаардлагагүй ижил төрлийн хувцас болон биеийн тамирын хувцас худалдан авсан байна | 5.2 | | 5.2 | | |
| 3 | Биеийн тамир, спортын газрын даргад тушаал шийдвэргүйгээр 0.7 сая төгрөгийн урамшуулал бодож олгосон байна. | 0.7 | | 0.7 | | |
| 4 | Байгууллагын төсвөөс 14.2 сая төгрөгөөр бэлэг дурсгалын зүйлс бэлтгэж, зарцуулсан | 14.2 | | 14.2 | | |
| 5 | Байгууллагын үйл ажиллагаанд хэрэгцээ шаардлагагүй, үр ашиггүй 54.4 сая төгрөгийн бараа материал бэлтгэсэн | 54.4 | | 54.4 | | |
| 6 | Төсвийн хөрөнгөөр 29.3 сая төгрөгийн согтууруулах ундаа худалдан авсан байна | 29.3 | | 29.3 | | |
| 7 | ЕБС-ууд нь хүүхдийн тоонд үндэслэж, бодит тооцоо хийхгүйгээр хүнсний материалыг хэт ихээр нөөцөлсөн харагдаж байна. Зарим материал нь дараагийн 2-3 жилд хангалттай хүрэлцэх үлдэгдэлтэй байна. | 0 | | | 1 | 0 |
| 8 | Сумдын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын үлдэгдэлд бүтэн жилийн турш хөдөлгөөн хийгдээгүй, хугацаа дууссан эмийг бүртгэлд тусгасан 26.0 сая төгрөгийн 12 зөрчил илэрсэн байна. | 0 | | | 1 | 0 |
| 9 | Өр төлбөрийг хэрхэн барагдуулах талаар орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн ТУЗ болон гүйцэтгэх удирдлагаас бодлогын шинжтэй арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй, ямар хугацаанд барагдуулах талаар тооцоолол, ажлын төлөвлөгөөг гаргаж ажиллахгүй байна. | | | | 2 | 0 |
| 10 | Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой компаниудыг үр ашигтай ажиллуулах нэгдсэн бодлогоор хангаагүй, ТУЗ-ийн цалин хөлсийг үр ашигтай уялдуулан тогтоодоггүй, компанийн бүтэц орон тоог оновчтой төлөвлөхгүй байна. | 0 | | | 2 | 0 |
| 11 | Компанийн чиг үүрэг бүтэц орон тоог үр ашигтай уялдуулан тогтоох | 0 | | | 1 | 0 |
| 12 | Аймгийн ИТХ-аар хэлэлцэж баталсан 6,195.7 сая төгрөгийн 31 төсөл арга хэмжээний төсөвт өртгийг 5,452.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж 11,648.5 сая төгрөг болгож баталсан байна. | 5452.9 | | | 2 | 5452.9 |
| 13 | Орон нутгийн өмчийн оролцоотой болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн худалдан авах ажиллагааг төлөвлөхдөө тендер шалгаруулалтын босго үнээс | 1 | 0 | | 1 | 0 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | зайлсхийж ижил төрлийн бараа ажил үйлчилгээний төсөвт өртгийг хувааж төлөвлөдөг нийтлэг зөрчил байна | | | | | |
| **14** | Аймгийн ЗДТГ-ын СТСХ нь хэмнэлтийн арга хэмжээний талаар хэрэгжүүлсэн ажил байхгүй, хяналтын тогтолцоо алдагдсан байна. | 1 | 0 | | 3 | 0 |
| **15** | Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн Төлөөлөн Удирдах зөвлөл, түүний Аудитын хорооноос Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хангамж, үйл ажиллагааны хязгаарлалт, үр ашигтай байх байдалд хийсэн хяналт байхгүй, Компаниудын ТУЗ-ийн аудитын хороо нь 2022-2024 онд огт хуралдаагүй байна. | 1 | 0 | | 1 | 0 |
| **16** | төсвийг бодит тооцоо судалгаанд үндэслэн үр ашигтай байхаар төлөвлөдөггүй байна | 1 | 0 | | 1 | 0 |
| **17** | компанийн засаглалтай холбоотой мэдээллийг бүх компаниуд цахим хуудсанд ил тод мэдээлээгүй байна | 1 | 0 | | 1 | 0 |
| | **НИЙТ** | **5,571.6** | **40** | **113.6** | **16** | **5,452.9** |

## Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал:

| ***Санал ирүүлсэн байгууллага*** | ***Ирүүлсэн санал:*** | ***Тайлбар:*** |
|---|---|---|
| **Аймгийн ИТХ** | ХӨВСГӨЛ АЙМГИЙН<br>ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН<br>ХУРЛЫН АЖЛЫН АЛБА<br>Нутгийн удирдлагын ордон, 3 давхар,<br>Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120.<br>Утас: (976) 7038 3330.<br>Цахим шуудан: aimginithural@khs.gov.mn<br>Цахим хуудас: Khovsgol.Khural.mn<br>2025.05.12 № 02/110<br>танай ______ -ны № ______ -т<br><br>ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН<br>АУДИТЫН ГАЗАРТ<br><br>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт үр дүн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн төсөлд хүргүүлэх саналгүй болно.<br><br>ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ<br>ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Х.ЦЭНД-АЮУШ | **Санал ирүүлээгүй байна.** |
| **Аймгийн Засаг дарга** | ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА<br>АЗДТГ-ын, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120<br>Утас: 70383303, Факс:<br>Цахим шуудан: huvsgulzdtg@khs.gov.mn<br>Цахим хуудас: https://khovsgol.gov.mn/<br>2025.05.09 № 1/1149<br>танай 2025.05.09 -ны № 1/409 -т<br><br>ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН<br>АУДИТЫН ГАЗАРТ<br><br>"Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн" нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.<br><br>Санал тайлбар байхгүй болно.<br><br>Хөвсгөл аймгийн засаг даргын тамгын газар<br>Засаг дарга<br>Лааган Төмөрбаатар<br>2025-05-09 17:58:50 | **Санал ирүүлээгүй байна.** |

| | | |
|---|---|---|
| **Аймгийн ЗДТГ-ын СТСХ** | ХӨВСГӨЛ АЙМГИЙН<br>ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР<br>АЗДТГ-ын байр, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120<br>Утас: 70383303, Факс:<br>Цахим шуудан: huvsgulzdtg@khs.gov.mn<br>Цахим хуудас: https://khovsgol.gov.mn/<br>2025.05.09 № 8/1144<br>танай ______ -ны № ______ -т<br>ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ТБАГУТҮГ<br>"Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн" нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Манай хэлтсийн зүгээс татгалзах зүйлгүй болно.<br>Хөвсгөл аймгийн засаг даргын тамгын газар<br>Санхүү төрийн сангийн хэлтэс<br>Хэлтсийн дарга<br>Гаваа Базар<br>2025-05-09 17:10:13 | **Санал ирүүлээгүй байна.** |
| **Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар** | ХӨВСГӨЛ АЙМГИЙН<br>СОЁЛ, УРЛАГ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ГАЗАР<br>Аймгийн ЗДТГ, Б корпус, Мөрөн сум, Хөвсгөл аймаг 67120<br>Утас: 70380638, Факс: 70380638<br>Цахим шуудан: khuvsgulsoyol@khs.gov.mn<br>Цахим хуудас: http://khs.moc.gov.mn/<br>2025.05.09 № 93<br>танай ______ -ны № ______ -т<br>ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ<br>"Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн" нийцлийн аудитын тайлантай танилцлаа. Цаашид соёл урлагийн байгууллагын үйл ажиллагааны онцлог, чиг үүрэгтэй уялдуулан улс, орон нутгийн томоохон арга хэмжээнд зарцуулагдах санхүүжилтийн тодорхой хувийг зочид төлөөлөгч хүлээн авах, албан хаагчдын ажил үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан гарах зайлшгүй зардалд тусгуулах саналтай байна.<br>Хөвсгөл аймгийн соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар<br>Удирдлага<br>Газрын дарга<br>Лочиндэмбэрэл Батцэцэг<br>2025-05-09 18:19:05 | **Ирүүлсэн саналыг нэгтгэсэн тайланд уламжлав.** |

<table>
<tr>
<td>Боловсролын газар</td>
<td>
ХӨВСГӨЛ АЙМГИЙН<br>БОЛОВСРОЛЫН ГАЗАР<br>Багшийн хөгжлийн ордон,<br>Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120<br>Утас: 7038 3693, Цахим шуудан: khuvsgul@mecs.gov.mn<br><br>
2025.05.12 № 150<br>танай ________-ны № ____________-т<br><br>
ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ<br>ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ<br><br>
Тайлбар хүргүүлэх тухай<br><br>
“Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн” нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Дараах тайлбарыг хүргүүлж байна.<br>
Тухайн санхүүгийн жил, хичээлийн жил 2 зөрүүтэй байгаагаас нэг оны санхүүгийн жил дууссан байхад хичээлийн жил дундаа үргэлжилдэг бөгөөд хичээл сургалтын үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах учир хүнсний хангамжийг тасралтгүй хэвийн явуулах зорилгоор материалыг тодорхой хэмжээнд байлгадаг. Шинэ санхүүгийн жил эхлэх үед төсөв батлагдаж ирэх, оны эхний саруудад хоолны мөнгө төсөв бага хуваарилагдах, тендер зарлах, тендерын гүйцэтгэгч шалгарах зэрэг олон шалтгаанаас хамаарч хүүхдийн хоолны материалын нөөцийг 1-2 сарын хэмжээнд (голлон мах, гурил, будаа гэх мэт хадгалалт сайтай бүтээгдэхүүн) бэлтгэн хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагааг доголдуулахгүй байлгах зорилготой болно.<br><br>
ДАРГА О.БАДРАА
</td>
<td>Тайлбарыг хүлээн авах боломжгүй байна.</td>
</tr>
</table>

*Хавсралт №1*

| Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой илэрсэн зөрчлийн мэдээлэл | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| /мянган төгрөгөөр/ | | | | | | | | | | | | | |
| **№** | **Аудитын он** | **Байгууллагын нэр** | **Хуули йн зүйл** | **Зөрчлийн утга** | **Нийт зөрчил** | | **Үүнээс** | | | | | | |
| | | | | | | | **Төлбөрийн акт** | | **Албан шаардлага** | | **Зөвлөмж** | | |
| | | | | | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | |
| **Санхүүгийн тайлангийн аудит** | | | | | | | | | | | | | |
| **1** | 2022 | ХИЛИЙН ЦЭРГИЙН 257-Р АНГИ | 6.1 | Дотод үйлчилгээнд автомашин ашиглаж шатахууны зардал гаргасан. | 1 | 796.3 | 1 | 796.3 | | | | | |
| **2** | 2022 | Хөвсгөл аймгийн ЗДТГ | 6.2 | Аймгийн Засаг даргаас бусад албан тушаалтан дотор үйлчилгээнд ашигласан | 1 | 673.4 | 1 | 673.4 | | | | | |
| **3** | 2022 | Хөвсгөл аймгийн ЗДТГ | 6.3 | Албан ажлын томилолт, удирдамж, ажлын тайлангүйгээр шатахууны зардал гаргасан. | 1 | 1,405.8 | 1 | 1,405.8 | | | | | |
| **4** | 2022 | Мөрөн сумын ЗДТГ | 6.3 | Багийн засаг дарга нар багт ажиллахад шатахуун зарцуулсан | 1 | 4,157.0 | | | 1 | 4,157.0 | | | |
| **5** | 2022 | Их-Уул дулаан ХХК | 7.1 | Урсгал засварын зардлаас конторын барилга бэлтгэсэн. | 1 | 39,900.0 | | | 1 | 39,900.0 | | | |
| **6** | 2022 | Тэсийн-Илч ХХК | 15.1.7 | Байгууллагын төсвөөс гар бөмбөгийн тэмцээний хувцас, архи, шампанск худалдан авсан. | 1 | 731.5 | 1 | 731.5 | | | | | |
| **7** | 2022 | Боловсролын газар | 9.3 | УБ хот, бусад аймагт зохион байгуулсан сургалт зардлыг зохион байгуулсан талаас санхүүжүүлсэн байхад байгууллагаас томилолт олгосон. | 1 | 917.6 | 1 | 917.6 | | | | | |
| **8** | 2022 | Жаргалант сумын ЕБС | 14.4 | Цахим хэрэглээний 6,593.7 мянган төгрөгийн төлбөрийг Цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, Юнител | 1 | 6,593.7 | | | | | 1 | 6,593.7 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | компанитай шууд гэрээ хийсэн байна. | | | | | | | | |
| **9** | 2022 | Цэцэрлэг сумын ЗДТГ | 12.1.1 | Эгшиглэнт-Үйлс ХХК-д 500.0 мянган төгрөгийг шилжүүлж 2000 төгрөгийн хоноггүй 250 нэгжийн карт худалдан авч зарцуулсан | 1 | 500.0 | 1 | 500.0 | | | | |
| **10** | 2022 | Чандмань-Өндөр сумын ИТХ | 12.1.1 | Байгууллагын төсвөөс 240,000 /хоёр зуун дөчин мянга/ төгрөгийг гар утасны зардалд зарцуулсан байна. | 1 | 240.0 | 1 | 240.0 | | | | |
| **11** | 2022 | Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ | 12.1.1 | Засаг дарга, ЗДТГ-ын дарга нарын нэгжийн төлбөрт 700.0 мянган төгрөг төлсөн. | 1 | 700.0 | 1 | 700.0 | | | | |
| **12** | 2022 | Түнэл сумын ЭМТ | 12.1.1 | эмнэлгийн ажилтан албан хаагчдад утасны нэгж худалдан авсан байна. | 1 | 2,531.0 | 1 | 2,531.0 | | | | |
| **13** | 2022 | Хөвсгөл эрчим хүч ХХК | 12.1.2 | Ээлжийн амралтаар нутаг явах замын зардал олгосон. | 1 | 538.0 | 1 | 538.0 | | | | |
| **14** | 2022 | Цагаан-Уул сумын ЗДТГ | 12.1.3 | Хэвлэл захиалгын төлбөр 31200 төгрөг төлсөн байна. | 1 | 31.2 | 1 | 31.2 | | | | |
| **15** | 2022 | Цагаан-Уул сумын ИТХ | 12.1.3 | 151,520 төгрөгийн хэвлэл захиалгын төлбөр төлсөн. | 1 | 151.5 | 1 | 151.5 | | | | |
| **16** | 2022 | Хөвсгөл эрчим хүч ХХК | 12.1.4 | Баяр ёслолын зардалд 4.7 сая төгрөг зарцуулсан. | 1 | 4,685.7 | | | 1 | 4,685.7 | | |
| **17** | 2022 | Хөвсгөл ус суваг ХХК | 13.1.3 | бизнес төлөвлөгөөгөөр батлагдсан урсгал зардлын задаргаанд хоолны зардал тусгагдаагүй байхад захирлын тушаалаар урсгал засварын ажил гүйцэтгэсэн ажилчдын хоолны зардалд 5.8 сая төгрөг зарцуулсан. | 1 | 5,871.9 | | | | | 1 | 5,871.9 |
| **18** | 2022 | Жаргалант сумын ЗДТГ | 13.3.1 | Хилийн цэсийн самбар, хаалга барьсан | 1 | 21,251.7 | | | 1 | 21,251.7 | | |
| **19** | 2022 | Хөвсгөл аймгийн Иргэдийн | 15.1.3 | Орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй зардал гарган намын суудлын мөнгө гэж | 1 | 82,000.0 | 1 | 82,000.0 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Төлөөлөгчдийн хурал | | нийт 82,000,000 төгрөгийг олгосон | | | | | | | | |
| **20** | 2022 | Мөрөн сумын ИТХ | 15.1.3 | ИТХ-д суудалтай намуудад суудлын мөнгө олгосон | 1 | 31,000.0 | 1 | 31,000.0 | | | | |
| **21** | 2022 | Хөвсгөл аймгийн ИТХ | 15.1.5 | Байгууллагын төсвөөс 775,000 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан. | 1 | 775.0 | 1 | 775.0 | | | | |
| **22** | 2022 | Цэцэрлэг сумын ЗДТГ | 15.1.5 | 230.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан | 1 | 230.0 | 1 | 230.0 | | | | |
| **23** | 2022 | Чандмань-Өндөр сумын ЗДТГ | 15.1.5 | төсвөөс 927.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан. | 1 | 927.0 | 1 | 927.0 | | | | |
| **24** | 2022 | Цагаан-Уул сумын ИТХ | 15.1.5 | төсвөөс 267,300 төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан, | 1 | 267.3 | 1 | 267.3 | | | | |
| **25** | 2022 | Хөвсгөл аймгийн ЗДТГ | 15.1.5 | бэлэг дурсгалын зүйл бэлтгэсэн | 1 | 3,903.8 | 1 | 3,903.8 | | | | |
| **26** | 2022 | Түнэл сумын ЗДТГ | 15.1.5 | шинэ байрны нээлтийн бэлэг 850,000 төгрөгийг төсвөөс зарцуулсан | 1 | 850.0 | 1 | 850.0 | | | | |
| **27** | 2022 | хүнс хөдөө аж ахуйн газар | 15.1.5 | 447.0 мянган төгрөгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан | 1 | 447.0 | 1 | 447.0 | | | | |
| **28** | 2022 | Түнэл Илч ХХК | 15.1.5 | Төсвийн хөрөнгөөр 957,500 төгрөгийн бэлэг бэлтгэсэн | 1 | 957.5 | 1 | 957.5 | | | | |
| **29** | 2022 | ХИЛИЙН ЦЭРГИЙН 257-Р АНГИ | 15.1.5 | Төсвөөс бэлэг дурсгалын зүйл бэлтгэсэн. | 1 | 2,548.6 | 1 | 2,548.6 | | | | |
| **30** | 2022 | Мөрөн сумын ЗДТГ | 15.1.6 | Сумын тэргүүн хүндэт тэмдэг жуух бичиг, өргөмжлөл цом гэх зүйлсийг нөөцөлсөн | 1 | 11,280.0 | | | 1 | 11,280.0 | | |
| **31** | 2022 | Арбулаг сумын ЕБС | 15.1.6 | Хангамжийн материалын үлдэгдлийг 2021 оны үлдэгдлээс 18,100.0 мянган төгрөгөөр өссөн байна. | 1 | 18,100.0 | | | | | 1 | 18,100.0 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **32** | 2022 | Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгоны ЕБС | 15.1.6 | Хангамжийн материалын үлдэгдлийг 2021 оны үлдэгдлээс 18,100.5 мянган төгрөгөөр өссөн байна. | 1 | 18,100.5 | | | | | 1 | 18,100.5 |
| **33** | 2022 | Орон нутгийн өмчийн газар | 15.1.7 | Төсвийн хөрөнгөөр согтууруулах ундаа авсан. | 1 | 223.1 | 1 | 223.1 | | | | |
| **34** | 2022 | Хөвсгөл аймгийн ИТХ | 15.2.3 | бүсийн сургалтад явахад зориулан бэлэг дурсгалын зүйл, ундаа, ус, хоол хүнсэнд нийт 3,182,800 төгрөгийн зардал гаргасан | 1 | 3,182.8 | 1 | 3,182.8 | | | | |
| **35** | 2022 | Тосонцэнгэл сумын ИТХ | 15.2.3 | 6,998,000 төгрөгийн хүнсний материал бэлтгэж, хурал сургалтын үйл ажиллагаанд зарцуулсан байна. | 1 | 6,998.0 | | | 1 | 6,998.0 | | |
| **36** | 2022 | Хөвсгөл аймгийн ЗДТГ | 15.2.3 | Сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон бусад арга хэмжээний хоолны зардал гаргасан. | 1 | 49,181.3 | | | 1 | 49,181.3 | | |
| **37** | 2022 | Статистикийн хэлтэс | 15.2.3 | Нэмэлт санхүүжилтийн данснаас 7,664,000 төгрөгийн сургалтын хоолны зардлыг санхүүжүүлсэн байна. | 1 | 7,664.0 | | | | | 1 | 7,664.0 |
| **38** | 2022 | Хөвсгөл ус суваг ХХК | 15.2.3 | Бизнес төлөвлөгөөг боловсруулахдаа холбогдох хууль тогтоомж баримтлаагүйгээс төрийн хэмнэлтийн хууль зөрчин 22.6 сая төгрөгийн зардал гаргасан | 1 | 22,627.3 | | | | | 1 | 22,627.3 |
| **39** | 2023 | Түнэл сумын ЗДТГ | 15.1.6 | төсвөөр ажилчдад биеийн тамирын хувцас захиалж 4,751,000.0 төгрөгийн төлбөрийг төлсөн. | 1 | 4,751.0 | 1 | 4,751.0 | - | - | - | - |
| **40** | 2023 | Хөдөөгийн шийдэл | 20.2 | ТХТХ-ийн 20 дугаар зүйлд заасан мэдээллийг мэдээлээгүй. | 1 | - | - | - | - | - | 1 | - |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **41** | 2023 | Засаг дарга данс | 12.1.3 | Эрүүл орчин-зөв ахуй байгууллагад сэтгүүлийн зардалд 2,000,000 (Хоёр сая) төгрөгийг нотлох баримтгүйгээр зарцуулсан. | 1 | 2,000.0 | 1 | 2,000.0 | - | - | - | - |
| **42** | 2023 | Улаан-Уул сумын ЗДТГ | 12.1.4 | 2023 онд төсвийн хөрөнгөөр баяр наадамд хэрэглэх зорилгоор нийт 2,049.1 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авсан. | 1 | 2,049.1 | 1 | 2,049.1 | - | - | - | - |
| **43** | 2023 | Баянзүрх сумын ЗДТГ | 12.1.4 | Байгууллагын төсвөөс алба хаагчдын эрүүл мэндийн үзлэгт хамруулах замын зардал гэж 2,960.0 төгрөгийг нярвын дансаар гарган авч, хоол, буудал, бусад бараа материал авч үр ашиггүй зарцуулсан. | 1 | 2,960.0 | 1 | 2,960.0 | - | - | - | - |
| **44** | 2023 | ХӨВСГӨЛ ЭРЧИМ ХҮЧ | 12.1.4 | Компанийн эзэмшилд байх спорт заалны түрээсийн орлогоос 7.1 сая төгрөгийг анхан шатны баримтгүйгээр, зориулалт бус зардалд зарцуулсан. | 1 | 7,132.3 | 1 | 7,132.3 | - | - | - | - |
| **45** | 2023 | ЦАГААН-УУЛ ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГ | 12.1.4 | Үр дүнгийн урамшууллыг 520,382 төгрөгөөр илүү олгосон байна. | 1 | 520.4 | 1 | 520.4 | | | | |
| **46** | 2023 | УЛААН-УУЛ ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГ | 12.1.4 | Тайлант онд байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр тухайн цэцэрлэг үнэлэгдээгүй байж багш нарт үр дүнгийн урамшуулал 4,898,575 төгрөгийг илүү бодож олгосон байна. | 1 | 4,898.6 | 1 | 4,898.6 | | | | |
| **47** | 2023 | Ренчинлхүмбэ сумын Орон нутгийн хөгжлийн сан | 13.3.1 | Рэнчинлхүмбэ сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар сумын угтах үдэх хаалга барьсан байна. | 1 | 9,000.0 | - | - | 1.0 | 9,000.0 | - | - |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **48** | 2023 | Төмөрбулаг сумын ЗДТГ | 15.1.3 | Байгууллагын төсвөөс төрийн албан хаагчдын тэмцээнд оролцсон тамирчдын буудлын зардалд 440.0 мянган төгрөг, хоолны зардалд 2,130.0 мянган төгрөг, нийт 2,570.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. | 1 | 2,570.0 | 1 | 2,570.0 | - | - | - | - |
| **49** | 2023 | Их-Уул сумын ЗДТГ | 15.1.3 | Хөвсгөл аймгийн Засаг даргын шийдвэргүйгээр 1,426,766 төгрөгийн үр дүнгийн урамшууллыг Их-Уул сумын Засаг даргад олгосон байна. | 1 | 1,426.8 | 1 | 1,426.8 | - | - | - | - |
| **50** | 2023 | ХӨВСГӨЛ ЭРЧИМ ХҮЧ | 15.1.3 | Хамтын гэрээний 5.31-д "Компанийн захиргаа, ҮЭ-ийн хороо хамтарч ажиллагсдын төлөөлөгчдийг жилд 1-ээс доошгүй удаа гадаад дотоодын тойрон аялалд зохион байгуулж явуулна" нь ТХТХ-д заасанд тус тус нийцэхгүй | 1 | - | - | - | 1.0 | - | - | - |
| **51** | 2023 | Баянзүрх сумын ЭМТ | 15.1.3 | Нийгэм эрүүл мэндийн зардалд тэмцээн урамшууллын зардал оруулж тооцсон | 1 | 411.6 | - | - | - | - | 1 | 411.6 |
| **52** | 2023 | Эрдэнэбулган сумын хүүхдийн цэцэрлэг | 15.1.3 | тайлант хугацаанд Багшийн хувцас -1080 000.00 төгрөг, Туслах багшийн хувцас -660,000.00  төгрөгийн зардал   гаргасан байна. | 1 | 1,740.0 | | | | | 1 | 1,740.0 |
| **53** | 2023 | ЧАНДМАНЬ-Өндөр сумын ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГ | 15.1.3 | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад тайлант хугацаанд Нормын хувцас | 1 | 720.0 | | | | | 1 | 720.0 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 720.0 мянган төгрөгийн зардал гаргасан байна. | | | | | | | | |
| **54** | 2023 | ИХ-УУЛ ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГ | 15.1.3 | Нормын хувцас -720 000.00 төгрөгийн зардал гаргасан. | 1 | 720.0 | | | | | 1 | 720.0 |
| **55** | 2023 | Чандмань-Өндөр ИТХ | 15.1.5 | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас 504900 төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авч иргэдэд бэлэглэсэн байна. | 1 | 504.9 | 1 | 504.9 | - | - | - | - |
| **56** | 2023 | Радио телевизийн сүлжээний газар | 15.1.5 | Тайлант онд 250.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс мөнгөн аягыг төсвийн хөрөнгөөр авч зарцуулсан. | 1 | 250.0 | 1 | 250.0 | - | - | - | - |
| **57** | 2023 | АЙМГИЙН ЗДТГАЗАР | 15.1.5 | төсвийн хөрөнгөөр нийт 345.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан байна. | 1 | 345.0 | 1 | 345.0 | - | - | - | - |
| **58** | 2023 | Арбулаг сумын ЗДТГ | 15.1.5 | 2023 онд бүсийн уулзалтад оролцогчдод бэлэглэх зорилгоор нийт 750.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан байна | 1 | 750.0 | 1 | 750.0 | - | - | - | - |
| **59** | 2023 | Хөвсгөл дулааны станц | 15.1.5 | Баяр ёслолын үйл ажиллагаанд зориулж зардал гаргасан. | 1 | 8,048.1 | 1 | 8,048.1 | | | | |
| **60** | 2023 | Засаг дарга данс | 15.1.5 | ахмад настны гарын бэлэг 31.3 сая төгрөг зарцуулсан байна. Тухайн гүйлгээний анхан шатны баримт олдохгүй болсон байна. | 1 | 31,311.5 | - | - | - | - | 1.0 | 31,311.5 |
| **61** | 2023 | Тосонцэнгэл сумын хүүхдийн цэцэрлэг | 15.1.6 | Бараа материалын дансанд 4 нэр төрлийн 1,995.0 мянган төгрөгийн бараа их хэмжээгээр бэлтгэн нөөцөлсөн | 1 | 1,995.0 | | | | | 1 | 1,995.0 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **62** | 2023 | Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ | 15.1.7 | Төсвийн хөрөнгөөр 272.6 мянган төгрөгийн архи бэлтгэн зарцуулсан байна. | 1 | 272.6 | 1 | 272.6 | - | - | - | - |
| **63** | 2023 | ХӨВСГӨЛ ЭРЧИМ ХҮЧ | 15.1.7 | 6. Байгууллагын төсвөөс 0.7 сая төгрөгөөр согтууруулах ундаа худалдан авсан. | 1 | 673.0 | 1 | 673.0 | - | - | - | - |
| **64** | 2023 | ЭРДЭНЭБУЛГАН ИТХ | 15.1.7 | төсвийн хөрөнгөөр 885,000 төгрөгийн согтууруулах ундаа авсан | 1 | 885.0 | 1 | 885.0 | - | - | - | - |
| **65** | 2023 | МӨРӨН сумын 10-Р ЦЭЦЭРЛЭГ | 15.2.1 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал гэрэл цахилгааны зардлыг хэтрүүлэн зарцуулсан | 1 | 1,295.3 | | | | | 1 | 1,295.3 |
| **66** | 2023 | МӨРӨН сумын 3-Р ЦЭЦЭРЛЭГ | 15.2.1 | Түлш халаалт, гэрэл цахилгааны зардлыг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 7,234.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн зарцуулсан. | 1 | 7,234.5 | | | | | 1 | 7,234.5 |
| **67** | 2023 | Тариалан нийтийн ахуй үйлчилгээний төв ХХК | 15.1.3 | МЦХК, мобиком, юнител, скайтелд тусламж, Аймгийн чуулганд оролцох сурагчдад дэмжлэгт зориулж хөрөнгө зарцуулсан | 1 | 1,400.0 | | | | | 1 | 1,400.0 |
| **68** | 2023 | Орон нутгийн өмчийн газар | 15.2.3 | Төвийн бүсийн аймгуудын сургалт зохион байгуулсан. | 1 | 5,000.0 | - | - | - | - | 1.0 | 5,000.0 |
| **69** | 2024 | Шинэ мөрөн худалдааны төв ХК | 6.2 | ИТХ-ын шийдвэрээр хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаагүй 19,600.0 мянган төгрөгийн өртөгтэй суудлын автомашин худалдан авч аймгийн ИТХ-ын ажлын албаны албан хэрэгцээнд балансаас балансад шилжүүлсэн нь тухайн байгууллагын чиг үүрэгт хамааралгүй байна. | 1 | 19,600.0 | | | 1 | 19,600.0 | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **70** | 2024 | Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК | 6.1 | Компанийн үйл ажиллагааг хувийн тээврийн хэрэгслээр гүйцэтгэдэг 11 албан хаагчид сар тутам олгох шатахууны нормативыг батлахдаа гүйцэтгэх захирлыг сар тутамд 100 литр шатахуунаар хангах тухай тушаал. | 1 | 5,451.0 | | | 1 | 5,451.0 | | |
| **71** | 2024 | Хөвсгөл аймгийн Ханх сумын Соёлын төв | 8.1 | Байгууллагын албан хаагчдад 500.0 мянган төгрөгийн хувцас хэрэглэл худалдан авсан байна. | 1 | 500.0 | 1 | 500.0 | | | | |
| **72** | 2024 | Хөвсгөл аймгийн Хатгал сумын Соёлын төв | 8.1 | Байгууллагын албан хаагчдад 210.0 мянган төгрөгийн хувцас хэрэглэл худалдан авсан байна. | 1 | 210.0 | 1 | 210.0 | | | | |
| **73** | 2024 | Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Соёлын төв | 8.1 | Байгууллагын ажилчдыг ижил хувцсаар жигдрүүлэх зорилгоор төсвийн хөрөнгөөр 622.0 мянган төгрөгийн хувцас худалдан авсан байна | 1 | 622.0 | 1 | 622.0 | | | | |
| **74** | 2024 | Хатгал тосгоны захирагчийн алба | 12.1.1 | Байгууллагын төсвөөс 200.0 мянган төгрөгөөр гар утасны нэгж худалдан авч албан хаагчдад өгсөн. | 1 | 200.0 | 1 | 200.0 | | | | |
| **75** | 2024 | ХАНХ ИТХ | 12.1.4 | Байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй зориулалтын бус зүйл худалдан авсан байна. | 1 | 1,444.3 | 1 | 1,444.3 | | | | |
| **76** | 2024 | Ханх сумын ЗДТГ | 12.1.4 | бичиг хэргийн материалыг тулган баталгаажуулалт хийхэд бичиг хэргийн зардлаас 4,504.3 мянган төгрөгийн байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй хувийн хэрэгцээний ахуйн материал худалдан авсан. | 1 | 4,504.3 | 1 | 4,504.3 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **77** | 2024 | ХӨВСГ АЙМАГ ДАХЬ ГААЛИЙН ХОРОО | 12.1.4 | төсвийн хөрөнгөөр 3126840 төгрөгийн байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй материал худалдан авсан байна. | 1 | 3,126.8 | 1 | 3,126.8 | | | | |
| **78** | 2024 | Худалдан авах ажиллагааны газар | 12.1.4 | Байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй зориулалтын бус зүйл худалдан авсан байна. | 1 | 540.9 | 1 | 540.9 | | | | |
| **79** | 2024 | Төмөрбулаг сумын Орон нутгийн хөгжлийн сан | 13.3.1 | Төмөрбулаг сумын ОНХС-ийн хөрөнгөөр 34.3 сая төгрөгийн өртөгтэй сумын угтах үдэх хаалга барьсан. | 1 | 34,300.0 | | | 1 | 34,300.0 | | |
| **80** | 2024 | Төмөрбулаг сумын ЗДТГ | 15.1.3 | Сумын Засаг даргын 2024 оны 9 сарын 27-ний өдрийн А/95 дугаар захирамжаар Шинэ-Идэр, Галт сумын 100 жилийн ойд зориулж 1,200.0 мянган төгрөгийн хандив өгсөн байна. | 1 | 1,200.0 | 1 | 1,200.0 | | | | |
| **81** | 2024 | эрчимт идэр сум дундын ойн анги | 12.1.4 | байгууллагын төсвөөс тус сумын соёлын төвд 1,000,000 (Нэг сая) төгрөгийн хандив өгсөн. | 1 | 1,000.0 | 1 | 1,000.0 | | | | |
| **82** | 2024 | Хөвсгөл аймаг дахь политехник коллеж | 15.1.4 | Хөвсгөл аймгийн багш нарын дундах спортын тэмцээнийг зохион байгуулахдаа олон нийтийн сүлжээнд шууд дамжуулах, тэмцээнтэй холбоотой контент хийлгэх зорилгоор 1,500.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. | 1 | 1,500.0 | 1 | 1,500.0 | | | | |
| **83** | 2024 | АЙМГИЙН ШШГ АЛБА | 15.1.5 | Төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл бэлтгэсэн, төсвийг зориулалт бусаар үр ашиггүй зүйлд зарцуулсан байна. | 1 | 1,940.5 | 1 | 1,940.5 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **84** | 2024 | Сод эрдэм ЕБС | 15.1.5 | бэлэг дурсгалын зүйл худалдан авсан | 1 | 744.0 | 1 | 744.0 | | | | |
| **85** | 2024 | Ирээдүй XXI зуун сургууль | 15.1.5 | Бэлэг дурсгалын зүйл худалдан авсан | 1 | 501.3 | 1 | 501.3 | | | | |
| **86** | 2024 | Мөрөн гурван эрдэнэ ЕБС | 15.1.5 | Багш нарын биеийн тамирын хувцас авсан | 1 | 250.0 | 1 | 250.0 | | | | |
| **87** | 2024 | Нутгийн аваргууд ЕБС | 15.1.5 | бэлэг дурсгалын зүйл худалдан авсан | 1 | 1,003.6 | 1 | 1,003.6 | | | | |
| **88** | 2024 | Эрдэнэбулган сумын ЗДТГ | 15.1.5 | 776,000.0 төгрөгийн байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй бэлэг дурсгалын зүйл авсан | 1 | 776.0 | 1 | 776.0 | | | | |
| **89** | 2024 | Мөрөн нисэх буудал | 15.1.6 | 2.3 сая төгрөгийн байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй материал авсан байна. | 1 | 2,302.1 | 1 | 2,302.1 | | | | |
| **90** | 2024 | ХӨВСГӨЛ АЗЗА | 15.1.5 | 1,062.4 мянган төгрөгөөр бэлэг дурсгалын зүйл бэлтгэсэн. | 1 | 1,062.4 | 1 | 1,062.4 | | | | |
| **91** | 2024 | Авьяас ЕБС | 15.1.5 | бэлэг дурсгалын зүйл худалдан авсан | 1 | 1,190.8 | 1 | 1,190.8 | | | | |
| **92** | 2024 | нийгмийн даатгалын газар | 15.1.5 | 1,143.7 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. | 1 | 1,143.7 | 1 | 1,143.7 | | | | |
| **93** | 2024 | Шинэ мөрөн худалдааны төв ХК | 15.1.5 | Шинэ жилийн үйл ажиллагаанд зориулж 2,500.0 мянган төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан. | 1 | 2,500.0 | 1 | 2,500.0 | | | | |
| **94** | 2024 | РАШААНТ ХҮН ЭМНЭЛЭГ | 15.1.6 | Бараа материалын дансанд бүтэн жилийн турш зарлагын хөдөлгөөн хийгдээгүй, өмнөх оноос шилжиж ирсэн эмийн үлдэгдэл байна. | 1 | 446.6 | | | 1 | 446.6 | | |
| **95** | 2024 | ТӨМӨРБУЛАГ ЭМНЭЛЭГ | 15.1.6 | Бараа материалын дансанд хугацаа дууссан эмийн үлдэгдэл байна. | 1 | 4,868.6 | | | 1 | 4,868.6 | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **96** | 2024 | Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын хүн эмнэлэг | 15.1.6 | Бараа материалын дансанд бүтэн жилийн турш зарлагын хөдөлгөөн хийгдээгүй, өмнөх оноос шилжиж ирсэн эмийн үлдэгдэл байна. | 1 | 4,016.0 | | | 1 | 4,016.0 | | |
| **97** | 2024 | Речинлхүмбэ сумын ЭМТ | 15.1.6 | Бараа материалын дансанд хугацаа дууссан эмийн үлдэгдэл байна. | 1 | 1,961.0 | | | 1 | 1,961.0 | | |
| **98** | 2024 | Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын хүн эмнэлэг | 15.1.6 | Бараа материалын дансанд бүтэн жилийн турш зарлагын хөдөлгөөн хийгдээгүй, өмнөх оноос шилжиж ирсэн эм, хугацаа дууссан ковид 19-ын эсрэг вакцины 7,867.224 төгрөгийн үлдэгдэл байна. | 1 | - | | | 1 | - | | |
| **99** | 2024 | АРБУЛАГ ХҮНИЙ ИХ ЭМЧИЙН САЛБАР | 15.1.6 | Бараа материалын үлдэгдэлд өмнөх оны үлдэгдлээс зарцуулаагүй эм, тан, тариа, вакцины 4123,0 мянган төгрөгийн үлдэгдэл байна | 1 | 4,123.0 | | | | | 1 | 4,123.0 |
| **100** | 2024 | БҮРЭНТОГТОХ ХҮН ЭМНЭЛЭГ | 15.1.6 | Бараа материалын үлдэгдэлд өмнөх оны үлдэгдлээс зарцуулаагүй эм, тан, тариа, вакцины 2224390.56 төгрөгийн үлдэгдэл байна | 1 | 2,224.4 | | | | | 1 | 2,224.4 |
| **101** | 2024 | ЖАРГАЛ ЭМНЭЛЭГ | 15.1.6 | Бараа материалын дансанд бүтэн жилийн турш зарлагын хөдөлгөөн хийгдээгүй, өмнөх оноос шилжиж ирсэн 24 нэрийн 609737 төгрөгийн үнэ эмийн үлдэгдэлтэй байна. | 1 | 609.7 | | | | | 1 | 609.7 |
| **102** | 2024 | Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр | 15.1.6 | Нормын хувцасны зардлаас 10 ширхэг, нэг бүр нь 150.0 мянган төгрөгийн үнэтэй | 1 | 1,500.0 | | | | | 1 | 1,500.0 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сумын Соёлын төв | | нийт 1500.0 мянган төгрөгийн үнэтэй хувцас /бомбор/ худалдан авч, 1 жилээс дээш бараа материалын дансанд үлдэгдэлтэй байсан байна. | | | | | | | | |
| **103** | 2024 | ЦАГААН-УУЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ | 15.1.6 | Бараа материалын дансанд бүтэн жилийн турш зарлагын хөдөлгөөн хийгдээгүй, өмнөх оноос шилжиж ирсэн 71 нэрийн 4442.6 мянган төгрөгийн эмийн үлдэгдэлтэй байна. | 1 | 4,442.6 | | | | | 1 | 4,442.6 |
| **104** | 2024 | ЦЭЦЭРЛЭГ ЭМНЭЛЭГ | 15.1.6 | Бараа материалын дансанд бүтэн жилийн турш зарлагын хөдөлгөөн хийгдээгүй, өмнөх оноос шилжиж ирсэн 25 нэрийн 1851.5 мянган төгрөгийн эмийн үлдэгдэлтэй байна. | 1 | 1,851.5 | | | | | 1 | 1,851.5 |
| **105** | 2024 | ЭРДЭНЭБУЛГАН ЭМНЭЛЭГ | 15.1.6 | Тайлант жилийн турш зарлагын хөдөлгөөн хийгдээгүй, өмнөх оноос шилжиж ирсэн 862.2 мянган төгрөгийн эмийн үлдэгдэл байгаа нь бараа материалын үлдэгдлийг эхэлж авснаа эхэлж зарлагадах аргыг тууштай мөрдөөгүй байна. | 1 | - | | | | | 1 | - |
| **106** | 2024 | АЙМГИЙН ИТХУРАЛ | 15.1.7 | 21.6 сая төгрөгөөр согтууруулах ундаа авсан. | 1 | 21,574.2 | 1 | 21,574.2 | | | | |
| **107** | 2024 | Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ | 15.1.7 | Төсвөөс 423.6 мянган төгрөгийн согтууруулах ундаа бэлтгэсэн. | 1 | 423.6 | 1 | 423.6 | | | | |
| **108** | 2024 | Бүрэнтогтох ИТХ | 15.1.7 | төсвийн хөрөнгөөр 1,862,000 төгрөгийн согтууруулах ундаа болон байгууллагын үйл | 1 | 1,862.6 | 1 | 1,862.6 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ажиллагаанд хамааралгүй материал худалдан авсан. | | | | | | | | |
| **109** | 2024 | Бүрэнтогтох сумын ЗДТГ | 15.1.7 | бичиг хэрэг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс худалдан авах зардлаас 5,054.7 мянган төгрөгийн согтууруулах ундаа болон байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй материал худалдан авсан | 1 | 5,054.7 | 1 | 5,054.7 | | | | |
| **110** | 2024 | МӨРӨН СУМЫН ИТХ | 15.1.7 | Байгууллагын төсвөөс 2,032,450 төгрөгийн архи согтууруулах ундаа худалдан авч төсвөөс үр ашиггүй зардал гаргасан. | 1 | 2,032.5 | 1 | 2,032.5 | | | | |
| **111** | 2024 | Орон нутгийн өмчийн газар | 15.1.7 | Байгууллагын төсвөөс 469,300 төгрөгийн согтууруулах ундаа бэлтгэсэн байна. | 1 | 469.3 | 1 | 469.3 | | | | |
| **112** | 2024 | Тосонцэнгэл сумын ЗДТГ | 15.1.7 | Төсвийн хөрөнгөөр 1,161.0 мянган төгрөгийн согтууруулах ундаа бэлтгэсэн байна | 1 | 1,161.0 | 1 | 1,161.0 | | | | |
| **113** | 2024 | Хөвсгөл аймаг дахь политехник коллеж | 15.1.6 | төсвийн хөрөнгөөр 916.8 мянган төгрөгийн согтууруулах ундаа болон байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй материал худалдан авсан. | 1 | 916.8 | 1 | 916.8 | | | | |
| **114** | 2024 | Хөвсгөл аймгийн ЗДТГ | 15.1.7 | бичиг хэрэг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс худалдан авах зардлаас 6,104,7 мянган төгрөгийн согтууруулах ундаа худалдан авсан байна | 1 | 6,104.7 | 1 | 6,104.7 | | | | |
| **115** | 2024 | Мөрөн сумын ЗДТГ | 15.1.7 | 6,030,850 төгрөгийн архи согтууруулах ундаа худалдан авч төсвийг үр ашиггүй, хэмнэлтгүй, | 1 | 6,030.9 | 1 | 6,030.9 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | зориулалт бусаар зарцуулж төсвийн сахилга батыг алдагдуулсан байна. | | | | | | | | |
| **116** | 2024 | Цагааннуур сумын ЗДТГ | 15.1.7 | төсвийн хөрөнгөөр 76,000.0 төгрөгийн согтууруулах ундааны зүйл худалдан авсан байна. | 1 | 76.0 | 1 | 76.0 | | | | |
| **117** | 2024 | Цэцэрлэг сумын ЗДТГ | 15.1.7 | төсвийн хөрөнгөөр 1,193,250 төгрөгийн согтууруулах ундаа авсан | 1 | 1,193.3 | 1 | 1,193.3 | | | | |
| **118** | 2024 | Хөвсгөл аймгийн Авто тээврийн төв | 15.1.7 | Төсвийн хөрөнгөөр 793,290 төгрөгийн согтууруулах ундаа худалдан авсан | 1 | 793.3 | 1 | 793.3 | | | | |
| **119** | 2024 | Хөвсгөл Ус суваг ХХК | 15.1.7 | Тус байгууллагын төсвөөс 0.8 сая төгрөгийн архи, согтууруулах ундаа, бэлтгэж төсвийг хэмнэлтгүй, үр ашиггүй, зориулалт бусаар, зарцуулсан байна | 1 | 826.1 | 1 | 826.1 | | | | |
| **120** | 2024 | Хөвсгөл эрчим хүч ХХК | 15.1.7 | Байгууллагын албан хаагчдад шампанск авч бэлэглэсэн байна | 1 | 1,700.0 | 1 | 1,700.0 | | | | |
| **121** | 2024 | Арбулаг сумын ЗДТГ | 15.1.7 | төсвийн хөрөнгөөр 2,947.1 мянган төгрөгийн согтууруулах ундаа болон байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй материал худалдан авсан. | 1 | 2,947.1 | 1 | 2,947.1 | | | | |
| **122** | 2024 | ДАЛАЙН-ЭЛБЭРЭЛТ | 15.1.7 | Байгууллагын төсвөөр 207.8 мянган төгрөгийн архи, согтууруулах ундаа худалдан авч, үр ашиггүй зардал гаргасан байна. | 1 | 207.8 | 1 | 207.8 | | | | |
| **123** | 2024 | ХӨВСГӨЛ-ЭНЭРЭЛ | 15.1.7 | Байгууллагын төсвөөр 348,450 төгрөгийн архи, согтууруулах ундаа худалдан авч, үр ашиггүй зардал гаргасан байна. | 1 | 348.5 | 1 | 348.5 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **124** | 2024 | ХӨВСГӨЛ ГУРВАН ГАЛ | 15.1.7 | Байгууллагын төсвөөр 207.8 мянган төгрөгийн архи, согтууруулах ундаа худалдан авч, үр ашиггүй зардал гаргасан байна. | 1 | 418.4 | 1 | 418.4 | | | | |
| **125** | 2024 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв | 15.1.7 | Төсвийн хөрөнгөөр 861.9 мянган төгрөгийн архи, согтууруулах ундаа бэлтгэсэн | 1 | 861.9 | 1 | 861.9 | | | | |
| **126** | 2024 | Хөдөлмөр халамж үйлчилгээний газар | 15.1.7 | Төсвийн хөрөнгөөр 3,076.9 мянган төгрөгийн согтууруулах ундаа бэлтгэн зарцуулсан байна. | 1 | 3,077.0 | 1 | 3,077.0 | | | | |
| **127** | 2024 | Энх үйлс Өрхийн эрүүл мэндийн төв | 15.1.7 | Байгууллагын төсвөөр 848.9 мянган төгрөгийн архи, согтууруулах ундаа худалдан авч, үр ашиггүй зардал гаргасан байна. | 1 | 848.9 | 1 | 848.9 | | | | |
| **128** | 2024 | МӨРӨН СУМЫН ИТХ | 12.1.4 | төсвөөс хоол хүлээн авалтын зардалд нийт 29,866,000 төгрөгийг зарцуулсан байна | 1 | 29,866.0 | | | 1 | 29,866.0 | | |
| **129** | 2024 | ГАЛТДУЛААН ХХК | 20.2. | ТХТХ-ийн 20 дугаар зүйлд заасан мэдээллийг мэдээлээгүй. | 1 | - | | | | | 1 | - |
| **130** | 2024 | ИХ УУЛ ДУЛААН | 20.2. | | 1 | - | | | | | 1 | - |
| **131** | 2024 | Тариалан нийтийн ахуй үйлчилгээний төв ХХК | 20.2. | | 1 | - | | | | | 1 | - |
| **132** | 2024 | Тосон илч ХХК | 20.2. | | 1 | - | | | | | 1 | - |
| **133** | 2024 | Тэсийн Илч ХХК | 20.2. | | 1 | - | | | | | 1 | - |
| **134** | 2024 | Түнэл-Илч ХХК | 20.2. | | 1 | - | | | | | 1 | - |
| | | **НИЙТ** | | | **134.0** | **656,255.4** | **86.0** | **263,756.1** | **18.0** | **246,962.8** | **30.0** | **145,536.5** |

*Хавсралт* **№2**

**Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлтэй холбоотой зөрчлийн жагсаалт**

*/төгрөгөөр/*

| д/д | Байгууллагын нэр | Нийт зөрчил | Үүнээс: | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Хуулийн 15.1.5 дахь заалттай холбоотой | Хуулийн 15.1.6 дахь заалттай холбоотой | Хуулийн 15.1.7 дахь заалттай холбоотой |
| 1 | Хөвсгөл аймгийн Боловсролын газар | 6,253,027.0 | 329,100.0 | 3,399,967.0 | 2,523,960.0 |
| 2 | Аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар | 1,152,622.0 | 468,100.0 | 433,022.0 | 251,500.0 |
| 3 | Биеийн тамир спортын газар | 8,357,396.0 | 1,468,000.0 | 4,466,446.0 | 2,422,950.0 |
| 4 | Мал эмнэлгийн газар | 4,563,715.0 | 556,500.0 | 2,410,915.0 | 1,596,300.0 |
| 5 | Хөвсгөл аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс | 1,578,530.0 | 244,700.0 | 742,830.0 | 591,000.0 |
| 6 | Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа | 325,200.0 | | | 325,200.0 |
| 7 | Хөдөөгийн шийдэл ХХК | 2,333,893.0 | | 1,766,393.0 | 567,500.0 |
| 8 | Эрүүл мэндийн газар | 4,238,870.0 | 957,400.0 | 1,566,430.0 | 1,715,040.0 |
| 9 | Байгаль орчны газар | 6,390,322.0 | | 2,514,900.0 | 3,875,422.0 |
| 10 | Алаг-Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэг | 2,313,504.0 | | 2,170,004.0 | 143,500.0 |
| 11 | Алаг-Эрдэнэ сумын ЭМТ | 2,543,738.0 | 162,000.0 | 1,494,738.0 | 887,000.0 |
| 12 | Арбулаг сумын хүүхдийн цэцэрлэг | 698,800.0 | 193,000.0 | 214,200.0 | 291,600.0 |
| 13 | Тосонцэнгэл сумын Соёлын төв | 1,008,186.0 | 309,000.0 | 342,836.0 | 356,350.0 |
| 14 | Тосонцэнгэл сумын ЭМТ | 2,600,039.0 | 225,000.0 | 1,581,939.0 | 793,100.0 |
| 15 | Бүрэнтогтох сумын ЭМТ | 2,742,041.0 | 250,000.0 | 1,950,541.0 | 541,500.0 |
| 16 | Бүрэнтогтох сумын хүүхдийн цэцэрлэг | 3,658,110.0 | 1,446,800.0 | 980,510.0 | 1,230,800.0 |
| 17 | Төмөрбулаг сумын ЭМТ | 2,547,623.0 | | 2,470,223.0 | 77,400.0 |
| 18 | Түнэл сумын ЕБС | 439,134.0 | | 431,634.0 | 7,500.0 |
| 19 | Цагааннуур сумын ЭМТ | 2,159,317.0 | 160,000.0 | 1,090,917.0 | 908,400.0 |
| 20 | Чандмань сумын ЭМТ | 624,580.0 | 45,000.0 | 535,450.0 | 44,130.0 |
| 21 | Чандмань-Эрдэнэ сумын ЕБС | 702,540.0 | 562,000.0 | 140,540.0 | |
| 22 | Мөрөн сумын Ерөнхий боловсролын Дэлгэрмөрөн сургууль | 5,595,566.0 | 920,900.0 | 3,642,316.0 | 1,032,350.0 |
| 23 | Мөрөн  сумын 1 дүгээр цэцэрлэг | 1,391,007.0 | 854,000.0 | 245,357.0 | 291,650.0 |
| 24 | Мөрөн сумын 5 дугаар цэцэрлэг | 2,702,935.0 | 526,000.0 | 1,489,385.0 | 687,550.0 |
| 25 | Мөрөн сумын 6 дугаар цэцэрлэг | 1,454,216.0 | 393,000.0 | 862,816.0 | 198,400.0 |
| 26 | Мөрөн сумын 7 дугаар цэцэрлэг | 1,013,767.0 | 110,000.0 | 903,767.0 | |
| 27 | Мөрөн сумын 10 дугаар цэцэрлэг | 758,884.0 | 216,000.0 | 459,084.0 | 83,800.0 |
| 28 | Мөрөн сумын 12 дугаар цэцэрлэг | 985,934.0 | 99,100.0 | 703,334.0 | 183,500.0 |
| 29 | Мөрөн сумын Ерөнхий боловсролын Сод-Эрдэм сургууль | 2,450,000.0 | 1,158,200.0 | 1,154,000.0 | 137,800.0 |
| 30 | Мөрөн сумын Ерөнхий боловсролын Гурван-Эрдэнэ сургууль | 2,972,050.0 | 1,254,250.0 | | 1,717,800.0 |
| 31 | Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар | 4,288,345.0 | | 2,465,645.0 | 1,822,700.0 |
| 32 | Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар | 2,921,140.0 | 793,000.0 | 149,250.0 | 1,978,890.0 |
| 33 | Дэлгэрмөрөн-Шишхэд голын сав газрын захиргаа | 8,632,754.0 | | 8,167,404.0 | 465,350.0 |
| 34 | Стандартчилал, хэмжил зүйн хэлтэс | 2,864,615.0 | | 2,864,615.0 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 35 | Шүүхийн тамгын газар | 817,400.0 | 151,500.0 | | 665,900.0 |
| 36 | Ахмадын асрамж үйлчилгээний газар | 774,300.0 | 371,000.0 | | 403,300.0 |
| 37 | Мөрөн сумын Ерөнхий боловсролын Эрдмийн далай сургууль | 585,000.0 | | 585,000.0 | |
| 38 | Их-Уул сумын ЭМТ | 438,900.0 | | | 438,900.0 |
| | **НИЙТ** | **97,878,000.0** | **14,223,550.0** | **54,396,408.0** | **29,258,042.0** |